



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жаанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023.01.10 № 35-1/15
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Женев хотноо 1958 онд батлагдсан "Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд зөвшилцөх, хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08.
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

дод.з. 01.04 № ХӨТ/81

танай _____-ны № _____-г

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Женев хотноо 1958 онд батлагдсан "Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ⁶¹ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж В/4,
Чингэлтай дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.12.27 № 116542
тантай 2022.12.23-ны № 01/5976 -т

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Танаас ирүүлсэн Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



151906153
A5 Файл.2022



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 88, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022.12.24 № 01/8864

ТЭВЭЙГ 2022.12.23-ны № 01/5978 -г

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу "Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулсан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр"-ийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001833



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

Эхостайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2022.12.27 № 09/6374
танай _____-ны № 01/3977 -т

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.



Б.БАТЦЭЦЭГ

115222099

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 61 дүгээр тэмдэглэлд:

“XIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд зөвшилцөх, хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... –ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Швейцарь Улсын Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг



“ДУГУЙТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД, ТЭДГЭЭРТ СУУРИЛУУЛАН АШИГЛАЖ БОЛОХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭД АНГИД ЗОРИУЛСАН НҮБ-ЫН УЯЛДУУЛАН ТОХИРУУЛСАН ТЕХНИКИЙН ДҮРМИЙГ ХЭРЭГЛЭХ БОЛОН НҮБ-ЫН ЭДГЭЭР ДҮРЭМД ҮНДЭСЛЭН ОЛГОСОН БАТАЛГААГ ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн дээд хэмжээний 70 дугаар чуулганаар “Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”-ийг хэлэлцэн баталж, “Тогтвортой дэд бүтэц, үйлдвэрлэл, инновацийг дэмжих” зорилтыг дэвшүүлсэн бөгөөд тус зорилтын хүрээнд улс орнууд тээврийн нэгдсэн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, тээврийн үйлчилгээг аюулгүй, шуурхай, тав тухтай хүргэх, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатай техник, технологийг хөгжүүлэхээр төлөвлөсөн.

Швед Улсын Стокгольм хотноо 2020 онд зохион байгуулагдсан Сайд нарын гуравдугаар хуралдаанаар дэлхий дахинд зарлан тунхагласан “Стокгольмын тунхаглал”-ын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэлхийн зорилтууд 2030”-д тусгасан 12 зорилтын 2 дахь зорилтод “2030 он гэхэд бүх улс орнууд замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой НҮБ-ын нэг буюу хэд хэдэн гол хууль эрх зүйн бичиг баримтыг хүлээн зөвшөөрч, нэгдэнэ” гэж, мөн 5 дахь зорилтод “2030 он гэхэд 100 хувь шинэ автомашин (үйлдвэрлэсэн, худалдагдсан, импортолсон) болон ашиглагдсан автомашинууд нь НҮБ-ын техникийн дүрмүүд, Дэлхийн техникийн зохицуулалт болон эдгээр бичиг баримттай нийцэхүйц үндэсний шаардлагууд зэрэг өндөр чанарын аюулгүй байдлын техникийн стандартуудад нийцсэн байна” гэж автотээврийн салбарын хөгжилд нийцсэн 2 гол зорилт багтсан юм.

“Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.6.3-д “байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ” гэж, 4.3.10-д “ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориулалттай тээврийн хэрэгсэл, автомашиныг камертай байх стандартыг тогтоож, баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг үе шаттайгаар хязгаарлах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна” гэж, 6.2.2-д “бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчлөнө” гэсэн зорилтыг

хэрэгжүүлэх хүрээнд “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах шаардлагатай байна.

1.2. Практик шаардлага

Ташкент хотноо 2016 оны 06 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн тэргүүн нарын гурав дахь уулзалтаар баталсан Монгол-Хятад-Оросын “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрт тусгасан нэг томоохон ажил бол дамжин өнгөрөх автотээврийн эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудал бөгөөд энэ ажлын хүрээнд Монгол, Хятад, Орос гурван улсын Засгийн газар хооронд Азийн авто замын сүлжээгээр олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын шаардлагыг хангах, бусад оронд мөрдөж буй хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх, өөрийн орны иргэд, аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалахад олон улсын хэмжээнд даган мөрдөж буй гэрээнд нэгдэн орох асуудал зүй ёсоор тавигдсан.

НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (НҮБЕЭЗК)-оос 2013¹, 2019², 2020³ онуудад Монгол Улсыг тус комиссын дотоодын тээврийн хорооноос боловсруулсан автотээврийн салбартай холбоотой олон улсын 8 конвенцид нэгдэн орохыг удаа дараа зөвлөж байсан.

Энэхүү олон улсын 8 конвенцид Монгол Улсын Их хурлаас соёрхон батлагдаж буй “Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээр”, тус яамнаас 2018 оноос хойш нэгдэн орохоор бэлтгэл ажлыг хангаж буй “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай 1958 оны хэлэлцээр”, “Аюултай ачаа тээвэрлэлтийн тухай хэлэлцээр”, “Хүнсний түргэн гэмтэх, муудах бүтээгдэхүүний тээвэрлэлт ба энэ төрлийн тээвэрлэлтэд ашиглагдах тусгай тоног төхөөрөмжийн тухай хэлэлцээр” зэрэг нь багтаж байгаа болно.

“Олон улсын автотээврийн харилцааны тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах явцад Хэлэлцэн тохиролцогч талуудын зүгээс олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийг байгаль орчинд ээлтэй, дуу чимээ багатай, аюулгүй байдлыг найдвартай хангасан дэвшилтэт технологи бүхий тээврийн хэрэгслийг ашиглах тухай тусгайлсан заалтыг хэлэлцээрт тусгаж өгдөг.

Монгол Улсын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдлын үзүүлэлтийг авч үзвэл Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 2021 оны жилийн эцсийн байдлаар 1,243,445 болж, өмнөх оны мөн энэ үеэс 116,669 (+10.35 хувь) тээврийн хэрэгслээр өссөн байна. Мөн цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 33.98 хувь, хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 11.8 дахин нэмэгдсэн байна⁴.

Зам тээврийн ослын сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлтээс үзэхэд жилд дунджаар 32100 зам тээврийн осол гарч, 13,2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1289

¹ НҮБЕЭЗК, 2013.09.03-ны өдрийн албан бичиг; МУ-ын Гадвад Харилцааны яамны Гэрээ эрх зүйн газар, 2013 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 4/5394 дүгээр албан бичиг;

² МУ-ын Гадвад харилцааны яам, 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 07/1200 дугаар албан бичиг; Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх Төв болон Олон улсын бусад байгууллагуудын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн холбооны улсад суугаа элчин сайдын яам, 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 03/19 дүгээр албан бичиг;

³ Женев хот дахь Монгол Улсын Элчин Сайдын яам, 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А-32/20/072 дугаар албан бичиг;

⁴ Зам тээврийн хөгжлийн яам, Статистикийн эмхэтгэл 2021

хүн гэмтэж, 558 хүн нас барсан үзүүлэлттэй байгаа бөгөөд осол, нас баралтын тоо төдийлөн буурахгүй байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын айл өрхийн гэрийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын 3200 орчим халаалтын зуух, 10 хувийг Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд, 4 хувийг үнс, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэр ялгаруулж байна гэсэн судалгаа гаргасан байна. Энэхүү судалгаанаас харахад тээврийн хэрэгсэл нь агаарын бохирдлыг үүсгэгч нэг эх үүсвэр болоод байна.

Сүүлийн жилүүдэд автомашины хэрэглээ улам ихэсч байгаатай холбогдуулан импортоор орж ирж буй тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэж байна.

Монгол Улсад дэлхийн олон улс орноос автомашин импортлох болсноор олон марк, загварын тээврийн хэрэгсэл гаалийн байгууллагад бүртгэгдэж байна. Импортлож байгаа автомашины ихэнх хувийг хуучин автомашин эзэлдэг.

Сүүлийн жилүүдэд импортлож байгаа хуучин автомашины тоо нэмэгдэж, ялангуяа тухайн улсдаа осол аваарт орсны улмаас эвдэрсэн, гэмтсэн автомашин ихээр импортлож байна. Мөн цацрагийн бохирдол илэрсэн, автомашины одометрийн заалт (гүйлт) болон автомашины аралын дугаарыг өөрчлөх замаар хуучин автомашинууд Монгол Улсын зах зээлд нийлүүлэгдэж байна.

Эдгээр эвдрэл, гэмтэлтэй тээврийн хэрэгсэл Монгол улсад ихээр импортлогдох болсон гол шалтгаан нь Монгол Улс импортын тээврийн хэрэгсэлд тавих хориг, түүнийг зохицуулах эрх зүйн орчин дутмаг, мөрдөгдөж буй хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой.

Иймд олон улсын хэмжээнд уриалж, шаардаж байгаа зохицуулалтыг бий болгох, үндэсний хэмжээнд тулгамдаж буй тээврийн хэрэгслийн аюулгүй, найдвартай байдлыг хангах, Монгол Улсын техникийн бичиг баримтад нийцсэн тээврийн хэрэгслийн импортыг дэмжих, худалдан борлуулах, үйлдвэрлэх, устгах, дахин боловсруулах үйл ажиллагаанд мөрдөх зохицуулалтыг бүрдүүлэх үүднээс энэхүү хэлэлцээрт нэгдэн орох шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлох талаар:

Энэхүү хэлэлцээрийг 1958 оны 3 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан бөгөөд 1959 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

Хэлэлцээрийн зорилго нь сорилын заалтуудыг гүйцэтгэхэд чиглэсэн нэгдсэн загвар, захиргааны үйл ажиллагааны албан ёсны баталгаа бүхий тохиролцогч талуудаас үйлдвэрлэл нь тохирч байгаа болон харилцан хүлээн зөвшөөрч байгаа тухайд гаргасан албан ёсны баталгаа бүхий НҮБ-ын олон улсын дүрмүүдийг (Хэлэлцээрийн хавсралт) боловсруулах эрх зүйн болон захиргааны үндсийг хангадаг. Ингэснээр дэлхий нийтийн аюулгүй байдлыг түвшинг дээшлүүлэх, хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгох төдийгүй дэлхийн хэмжээнд техникийн нэгдсэн зохицуулалтыг бий болгох замаар тээврийн хэрэгсэл, түүний эд анги, тоноглолын ашиглалт, ажлын тодорхойломжийг сайжруулахад оршино.

Энэхүү хэлэлцээрээр шинэ механикжсан тээврийн хэрэгсэл болон механикжсан тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн тухайд ижил төрлийн шаардлагыг тогтоох, мөн энэ хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын техникийн дүрмүүдийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг зохицуулсан.

Хэлэлцээрт нэгдэхдээ хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын техникийн дүрмийг бүхэлд нь авч хэрэглэх үүрэг хүлээхгүй бөгөөд хэрэв шаардлагатай бол өөрийнхөө хэрэглэхийг хүссэн заалтуудыг сонгон авч хэрэглэж болно.

Хуулийн төсөл нь "Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр"-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай" гэсэн нэг зүйлтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналын талаар:

Энэхүү хэлэлцээрийг соёрхон баталснаар дараах ач холбогдолтой:

- Дугуйт тээврийн хэрэгсэл, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангийг олон улсад тавигдаж буй хийцийн, аюулгүй байдлын болон ашиглалтын бүхий л цогц шаардлагын дагуу үйлдвэрлэж, экспортлох боломж бүрдэнэ.

- Монгол Улсад үйлдвэрлэсэн дугуйт тээврийн хэрэгсэл, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангийг энэхүү хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч талууд, ажиглагч болон зөвлөх гишүүнчлэлтэй орнууд бүрэн хүлээн зөвшөөрнө.

- Бусад улс оронд үйлдвэрлэн гаргасан дугуйт тээврийн хэрэгсэл, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид доголдол, гэмтэл үүссэн, стандартаар болон техникийн дүрмээр тавигдсан шаардлагад нийцээгүй, мөн үйлдвэрлэгчийн мэдээлсэн үзүүлэлтэд тохирохгүй байх нөхцөлд НҮБ-д байгууллагад мэдэгдэх, алдааг засаж залруулах, шаардлага хангасан тээврийн хэрэгсэл, эд ангийг импортлох боломж бүрдэнэ.

- Шаардлагад нийцээгүй болон эвдрэл, гэмтэлтэй автомашин, хуурамч сэлбэг, эд ангийг Монгол Улсын нутагт дэвсгэрт нэвтрүүлэхгүй байх зохицуулалттай болно.

- Хэлэлцээрийг соёрхон баталснаар тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд олон улсын жишигт нийцсэн тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, эд ангийг ашиглана.

- Тээврийн хэрэгслийн техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаснаар зам тээврийн осол, ослоос үүдэлтэй хүний амь нас, эд хөрөнгийн хохирлын хэмжээ буурна.

- Хэлэлцээрийг хэрэгжүүлснээр энэ чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагууд, их, дээд сургууль, коллеж болон автомашин борлуулагчид, дистрибютер, диллерийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол Улсын хөгжилд төр, хувийн хэвшлийн хамтын оролцоог хангана.

- Улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй бөгөөд тээврийн хэрэгсэл, түүний тоног төхөөрөмж, эд ангийг экспортлох, импортлох, үйлдвэрлэх, ашиглалтын үеийн аюулгүй байдал, байгаль орчны нөлөөллийн үзүүлэлтийг сайжруулан эрх зүйн орчинг боловсронгуй болгох, олон улсын худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах ач холбогдолтой.

Монгол Улс нь энэхүү хэлэлцээрийг соёрхон баталснаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад батламж хүргүүлэх ба энэхүү батламжид "Монгол Улс нь

зөвхөн үндсэн хэлэлцээрийг хүлээн зөвшөөрнө. Гэхдээ хэлэлцээрийн 10 дугаар зүйл нь Монгол Улсад хамаарахгүй. Монгол Улс нь үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр болсон Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх журмуудыг өргөн мэдүүлэх үүрэг хүлээнэ" гэсэн тунхаглалыг хавсарган хүргүүлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүйд тооцох хуулийн талаарх саналын талаар:

Хуулийн төсөл нь Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, эсвэл хууль шинээр батлах шаардлагагүй бөгөөд техник, технологийн дэвшлийг даган шинэчлэгдэж байдаг техникийн дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгсэл, түүний тоног төхөөрөмж, эд ангитай холбоотой стандарт, техникийн баримт бичиг боловсруулах болно.

--- ооо ---

ТАНИЛЦУУЛГА

Олон улсын хэмжээнд, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн дээд хэмжээний 70 дугаар чуулганаар "Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030"-ийг хэлэлцэн баталж, "Тогтвортой дэд бүтэц, үйлдвэрлэл, инновацийг дэмжих" зорилтыг дэвшүүлсэн. Тус зорилтод улс орнууд тээврийн нэгдсэн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, тээврийн үйлчилгээг аюулгүй, шуурхай, тав тухтай, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй хөгжүүлэхээр төлөвлөсөн.

Швед Улсын Стокгольм хотноо 2020 онд зохион байгуулагдсан Сайд нарын гуравдугаар хуралдаанаар дэлхий дахинд зарлан тунхагласан "Стокгольмын тунхаглал"-ын "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэлхийн зорилтууд 2030"-д тусгасан 2 дахь зорилтод "2030 он гэхэд бүх улс орнууд замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой НҮБ-ын нэг буюу хэд хэдэн гол хууль, эрх зүйн бичиг баримтыг хүлээн зөвшөөрч, нэгдэнэ" гэж, мөн 5 дахь зорилтод "2030 он гэхэд 100 хувь шинэ автомашин (үйлдвэрлэсэн, худалдсан, импортолсон) болон ашиглагдсан автомашинууд нь НҮБ-ын техникийн зохицуулалтууд, Дэлхийн техникийн зохицуулалт болон эдгээр бичиг баримттай нийцэхүйц үндэсний шаардлагууд зэрэг өндөр чанарын аюулгүй байдлын техникийн стандартуудад нийцсэн байна" гэж автотээврийн салбарын хөгжилд нийцсэн 2 гол зорилт багтсан юм.

Олон улсын хэмжээнд тавигдаж буй эдгээр зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус яамнаас НҮБ-ын тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалт, худалдаа, импорт, үйлдвэрлэлт болон тээврийн хэрэгслийн жолоочийн ажил амралтын горим, аюултай ачаа тээвэр, түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлтийн олон улсын гэрээнд нэгдэн орохоор ажиллаж байна.

Үүний нэг нь "Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр (1958)" болно.

Энэхүү хэлэлцээр нь 1958 оны 3 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдаж, 1959 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Хэлэлцээрт 1968 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 1995 оны 10 дугаар сарын 16-ны өдөр дахин хянагдсан. Үүнээс хойш уг хэлэлцээр нь 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр шинэчлэгдсэн.

Энэхүү 1958 оны хэлэлцээрээр шинэ механикжсан тээврийн хэрэгсэл болон механикжсан тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн тухайд ижил төрлийн шаардлагыг тогтоох, мөн энэ хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын техникийн зохицуулалтуудыг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг зохицуулсан.

Хэлэлцээрийн зорилго нь сорилын заалтуудыг гүйцэтгэхэд чиглэсэн нэгдсэн загвар, захиргааны үйл ажиллагааны албан ёсны баталгаа бүхий, тохиролцогч талуудаас үйлдвэрлэл нь тохирч байгаа болон харилцан хүлээн зөвшөөрч байгаа тухайд гаргасан албан ёсны баталгаа бүхий НҮБ-ын олон улсын зохицуулалтыг бүрдүүлэх эрх зүйн болон захиргааны үндсийг хангадаг.

Хэлэлцээрт нэгдэхдээ хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын техникийн зохицуулалтыг бүхэлд нь авч хэрэглэх үүрэг хүлээхгүй бөгөөд, хэрэв шаардлагатай байгаа бол өөрийнхөө хэрэглэхийг хүссэн заалтуудыг сонгон авч хэрэглэж болно.

Үндсэн хэлэлцээрийн 2017 онд шинэчлэн боловсруулагдсан сүүлийн хувилбар нь удиртгал хэсэг, 16 зүйл, нэмэлт 1 хавсралтаас бүрдэж байна. Уг

хавсралтад захиргааны хорооны бүтэц, үйл ажиллагааны дүрэм, захиргааны болон үйл ажиллагааны заалтын 8 хавсралтыг тусгасан байна.

Хэлэлцээрийн шинэ хувилбарт үйл ажиллагааны заалтын 8 хавсралтыг нарийвчлан оруулсан байна. Нэгд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тохирлын журам, хоёрт, техникийн үйлчилгээний байгууллагын үнэлгээ, томилгоо болон мэдэгдэл, гуравт, НҮБ-ын загварын баталгааны журам, дөрөвт, НҮБ-ын загварын баталгааг дугаарлах, тавд, баталгааны баримт бичгийг түгээх, зургаад, НҮБ-ын дүрмийн дагуу олгох загварын баталгаа болон НҮБ-ын дүрмийг хэрэглэхтэй холбоотой тайлбарын асуудлыг шийдвэрлэх журам, долоод, шинэ технологитой холбоотой шаардлагаас чөлөөлөх баталгааны журам, наймд, виртуал туршилтын аргын ерөнхий нөхцлийг тус тус тусгасан байна.

Одоогоор 1958 оны энэхүү хэлэлцээрт 50 хэлэлцэн тохиролцогч тал оролцдог бөгөөд түүний хавсралтад НҮБ-ын 145 техникийн дүрэм багтдаг. НҮБ-ын техникийн дүрэм нь техникийн дэвшилттэй зэрэгцэн өөрчлөгддөг бөгөөд хэрэв шаардлагатай бол Хэлэлцэн тохиролцогч талуудын техникийн болон улс төрийн зөвлөмж, шинжлэх ухааны мэдлэг болон технологийн дэвшлийг харгалзан шинэчлэгддэг байдаг.

Хэлэлцээрийн хавсралт болох 145 техникийн дүрэмд дор дурдсан асуудлууд тусгагдсан байдаг. Үүнд:

Дугуйт тээврийн хэрэгсэл түүний эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийн

а/ Зураг төсөл зохиох;

б/ үйлдвэрлэх;

в/ баталгаажуулах;

г/ ашиглах;

д/ аюулгүй байдал /идэвхтэй, идэвхгүй, экологийн, замын хөдөлгөөний аюулгүй байдал/ зэрэг нь тусгагдсан.

Энэхүү хэлэлцээрт нэгдэн орсноор дараах ач холбогдолтой:

▪ Дугуйт тээврийн хэрэгсэл болон түүн дээр суурилуулан ашиглах боломжтой тоног төхөөрөмж, эд ангийг олон улсад тавигдаж буй хийцийн, аюулгүй байдлын болон ашиглалтын бүхий л цогц шаардлагын дагуу үйлдвэрлэж, улмаар экспортлох боломж үүснэ.

▪ Монгол Улсад үйлдвэрлэсэн дугуйт тээврийн хэрэгсэл болон түүн дээр суурилуулан ашиглах боломжтой тоног төхөөрөмж, эд ангийг энэхүү хэлэлцээрт нэгдэн орсон гишүүн орон, ажиглагч болон зөвлөх гишүүнчлэлтэй орнууд бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө.

▪ Бусад оронд үйлдвэрлэсэн дугуйт тээврийн хэрэгсэл болон түүн дээр суурилуулан ашиглах боломжтой тоног төхөөрөмж, эд ангийг өөрийн улсад ашиглах нөхцөлийг хөнгөвчлөх боломж бүрдэнэ.

▪ Бусад улс оронд үйлдвэрлэн гаргасан дугуйт тээврийн хэрэгсэл болон түүн дээр суурилуулан ашиглах боломжтой тоног төхөөрөмж, эд ангийг хяналт тавих, тэдгээрт үүссэн доголдол, гэмтэл үүссэн, стандарт болон зохицуулалтаар тавигдсан шаардлагад нийцээгүй, мөн үйлдвэрлэгчийн мэдээлсэн үзүүлэлтэд тохирохгүй байх нөхцөлд тэр тухай бүрэн эрхийнхээ дагуу тогтоох, мэдэгдэх, мэдэгдлээ хамгаалах, өөрийгөө гэрчилгээжүүлэх чадамжтай байгууллагыг байгуулах боломж үүснэ.

- Хэлэлцээрийн дагуу хийгдэж байгаа бүхий л үйл ажиллагаанд оролцож, өөрийн гишүүнчлэлийн хүрээнд зохицуулалт, журамд өөрчлөлт оруулахаар санал өгөх, зарим саналаас татгалзах эрх үүснэ.

- Шинэ техник, технологийн хөгжлөөс хамаарч өөрчлөгдөж байгаа техникийн дүрэм, шаардлага зэргийн талаарх мэдээллээр түргэн шуурхай хангагдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2017 оны 10 дугаар сарын 20

ХЭЛЭЛЦЭЭР

Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд¹ үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай

Шинэчилсэн хувилбар 3

(2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтийг багтаасан)

Энэхүү баримт бичгийг зөвхөн мэдээллийн зорилгоор ашиглана.

Хууль ёсны дагаж мөрдөх эх бичвэр нь: ECE/TRANS/WP.29/2016/2.



Нэгдсэн Үндэстний Байгууллага

¹Хэлэлцээрийн хуучин нэр:

Женев хотноо 1958 оны 03 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан Механиксын тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж, эд ангид зориулсан нэгдсэн нөхцөлийг батлах болон тэдгээрийн баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр (анхны хувилбар);

Женев хотноо 1995 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах болон эдгээр шаардлагад үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр (шинэчилсэн хувилбар 2).

Гарын үсэг / Signature 
2022 оны 03 сарын 16 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

**ДУГУЙТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД, ТЭДГЭЭРТ СУУРИЛУУЛАН АШИГЛАЖ
БОЛОХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭД АНГИД НҮБ-ЫН УЯЛДУУЛАН ТОХИРУУЛСАН
ТЕХНИКИЙН ДҮРМИЙГ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ БОЛОН НҮБ-ЫН ЭДГЭЭР ДҮРЭМД
ҮНДЭСЛЭН ОЛГОСОН БАТАЛГААГ ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ
НӨХЦӨЛИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР**

Удиртгал

Хэлэлцэн тохиролцогч талууд,

Женев хотноо 1958 оны 3 дугаар сарын 20-ны өдөр байгуулж, 1995 оны 10 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан "Механикжсан тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж, эд ангид нэгдсэн баталгааны нөхцөлийг хэрэглэх болон тэдгээрийн баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр"-т нэмэлт, өөрчлөлт оруулахаар **ШИЙДВЭРЛЭЖ**,

Зарим дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд ангиудыг өөрийн улс, бүс нутагт ашиглахад хангалттай НҮБ-ын техникийн дүрмийг тодорхойлох замаар олон улсын худалдаанд учирч буй техникийн саад тотгорыг багасгахыг ХҮСЭЖ,

Техникийн хөгжлийн дэвшилттэй уялдсан, техникийн болон эдийн засгийн үндэслэл бүхий зохицуулалтыг шинэчлэн сайжруулах зорилгоор дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангийн аюулгүй байдал, байгаль орчны хамгаалал, эрчим хүчний хэмнэлт, хулгайн гэмт хэргээс хамгаалахын ач холбогдлыг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**,

НҮБ-ын эдгээр дүрмийг өөрийн улс, бүс нутагт боломжит хэмжээнд хэрэгжүүлэхийг ХҮСЭЖ,

НҮБ-ын эдгээр дүрмийн дагуу Хэлэлцэн тохиролцогч өөр нэг талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас баталсан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийг өөрийн улсад хүлээн зөвшөөрөх үйл явцыг хөнгөвчлөхийг ХҮСЭЖ,

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд Тээврийн хэрэгслийн иж бүрэн загварын баталгааны олон улсын систем (ТХИБЗБОУС)-ийг бий болгож, энэхүү хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын дүрэм бүрийн давуу талыг нэмэгдүүлэх, үүний үр дүнд боломжийг бий болгох, Хэлэлцэн тохиролцогч талуудын хэрэгжилтийг хялбарчлах, тээврийн хэрэгсэлд бүхэлд нь олгосон иж бүрэн загварын баталгааг илүү өргөн хүрээнд харилцан хүлээн зөвшөөрөхийг ХҮСЭЖ,

Хэлэлцээрийн үйлчлэл болон найдвартай байдлыг дээшлүүлэх замаар хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч талын тоог нэмэгдүүлэх, хэлэлцээрийг автомашины салбарын техникийн зохицуулалтыг уялдуулахад олон улсын үндсэн систем болгон хэрэгжүүлэхийг ХҮСЭЖ,

Дараах зүйлийг **ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОВ**:



1 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч талууд нь энэхүү хэлэлцээрийн хавсралтад заасан үйл ажиллагааны журмын дагуу Хэлэлцэн тохиролцогч бүх талаас бүрдсэн Захиргааны хороогоор дамжуулан, мөн дор дурдсан зүйл, заалтад үндэслэн дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж болон эд ангид зориулсан НҮБ-ын дүрмийг батална. Загварын баталгаагаар дамжуулан дүрмийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн Хэлэлцэн тохиролцогч талууд ашиглахад зориулж загварын баталгаа олгох болон тэдгээрийг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг мөн тусгана.

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор:

"Дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд анги" гэж тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, байгаль орчны хамгаалал, эрчим хүчний хэмнэлт болон хулгайн халдлагаас урьдчилан сэргийлэх технологийн шийдэл бүхий аливаа дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд анги хамаарна;

"НҮБ-ын дүрмийн дагуу олгосон загварын баталгаа" гэж Хэлэлцэн тохиролцогч талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага шаардлагатай хяналт/шалгалт хийсний дараа үйлдвэрлэгчээс ирүүлсэн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангид нь тухайн НҮБ-ын дүрмийн шаардлагыг хангаж байгааг зарлах захиргааны журмыг хэлнэ. Үүний дараа үйлдвэрлэгч нь түүний зах зээлд гаргаж байгаа тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд анги бүр батлагдсан бүтээгдэхүүнтэй яг ижил түвшинд үйлдвэрлэгдсэн болохыг батална.

"Тээврийн хэрэгслийн иж бүрэн загварын баталгаа" гэж НҮБ-ын дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийн холбогдох дүрмийн дагуу олгосон төрөл бүрийн загварын баталгааг ТХИБЗБОУС-ийн удирдлагын системд заасны дагуу нэгтгэсэн тээврийн хэрэгслийн иж бүрэн баталгааг хэлнэ.

"НҮБ-ын дүрмийн хувилбар" гэж НҮБ-ын дүрэмд түүнийг батлагдсаны дараа энэхүү хэлэлцээрт заасан журмын дагуу, ялангуяа 12 дугаар зүйлд заасны дагуу дараа дараагийн нэмэлт, өөрчлөлт оруулж болохыг хэлнэ. Нэмэлт, өөрчлөлт оруулаагүй НҮБ-ын дүрэм болон дараа дараагийн нэмэлт, өөрчлөлтийг орсон НҮБ-ын дүрмийг уг НҮБ-ын дүрмийн тус тусдаа хувилбар гэж үзнэ.

"НҮБ-ын дүрмүүдийг хэрэглэх" гэж НҮБ-ын дүрмүүд Хэлэлцэн тохиролцогч талын хувьд хүчин төгөлдөр үйлчилж эхлэхийг хэлнэ. Ингэхдээ Хэлэлцэн тохиролцогч талууд өөрийн үндэсний/бүс нутгийн хууль тогтоомжийг хэвээр мөрдөх боломжтой. Хэрэв хүсвэл өөрийн үндэсний/бүс нутгийн хууль тогтоомжийг өөрийн хэрэглэж буй НҮБ-ын дүрмийн шаардлагаар өөрчилж болох боловч тэд энэхүү хэлэлцээрээр заавал ийм үүрэг хүлээхгүй. Гэхдээ Хэлэлцэн тохиролцогч талууд өөрийн үндэсний/ бүс нутгийн хууль тогтоомжийн холбогдох хэсэгт НҮБ-ын дүрмийг орлуулж буйн хувьд тухайн улсад/ бүс нутагт хүчин төгөлдөр үйлчилж буй НҮБ-ын дүрмийн хамгийн сүүлчийн хувилбарын дагуу олгосон НҮБ-ын загварын баталгааг хүлээн зөвшөөрнө. НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх, үүргийг энэхүү хэлэлцээрийн холбогдох зүйл, заалтад дэлгэрэнгүй тусгасан.



НҮБ-ын дүрмийг хэрэглэх тухайд загварын баталгаанаас гадна төрөл бүрийн захиргааны журмыг хэрэглэж болно. Европын эдийн засгийн холбооны зарим гишүүн улсад нийтлэг танигдаж, хэрэглэгддэг цорын ганц хувилбар бол үйлдвэрлэгчийн захиргааны ямар нэг урьдчилсан хяналтгүйгээр зах зээлд гаргаж байгаа бүтээгдэхүүн нэг бүр тухайн НҮБ-ын дүрмийн шаардлагад нийцэж байгаа гэдгийг өөрөө баталгаажуулах/гэрчилгээжүүлэх юм; эрх бүхий захиргааны байгууллага зах зээл дээрээс түүвэрлэн шалгах замаар өөрөө батлах уг бүтээгдэхүүн нь тухайн НҮБ-ын дүрмийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягталж болно.

2. Захиргааны хороо нь хавсралтад заасан үйл ажиллагааны журмын дагуу Хэлэлцэн тохиролцогч бүх талаас бүрдэнэ.

Хавсралтад заасан журмын дагуу батлагдсан аливаа НҮБ-ын дүрмийг Захиргааны хороо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга (цаашид "Ерөнхий нарийн бичгийн дарга" гэх)-д хүргүүлнэ. Үүний дараа Ерөнхий нарийн бичгийн дарга уг НҮБ-ын дүрмийн талаар Хэлэлцэн тохиролцогч бүх талуудад нэн даруй мэдэгдэнэ.

Ерөнхий нарийн бичгийн даргын мэдэгдлээс хойш 6 сарын дотор Хэлэлцэн тохиролцогч талуудын тавны нэгээс дээш хувь нь НҮБ-ын дүрмийг үл зөвшөөрч байгаа тухай Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдээгүй бол уг НҮБ-ын дүрмийг батлагдсанд тооцно.

НҮБ-ын дүрэмд дараах зүйлсийг тусгана:

- (a) Холбогдох дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд анги;
- (b) Техникийн шаардлагууд нь боломжтой тохиолдолд аль болох гүйцэтгэлийн үзүүлэлтэд чиглэсэн, хийц загварыг хязгаарлаагүй, боломжит техник технологи, зардал болон үр ашгийг тооцсон байх ба боломжит хувилбарын сонголтыг багтаасан/агуулсан байж болно;
- (c) гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах туршилтын арга;
- (d) захиргааны заалт/удирдлагын нөхцөлүүд, аливаа загварын баталгааны тэмдэг болон бүтээгдэхүүний тохирлын баталгааны шаардлага/нөхцөлүүдийг багтаасан загварын баталгаа олгох болон тэдгээрийг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлүүд;
- (e) Хэлэлцэн тохиролцогч талууд НҮБ-ын дүрмийн дагуу баталгаа олгох огноо болон баталгааг хүлээн зөвшөөрч эхлэх огноо (хэрэв өөр бол)-г багтаасан НҮБ-ын дүрэм хүчин төгөлдөр болох огноо;
- (f) Үйлдвэрлэгчээс өгөх мэдээллийн баримт бичиг.

Шаардлагатай тохиолдолд НҮБ-ын дүрэмд эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжилсэн, албан ёсоор баталгаажуулахаар ирүүлсэн дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангид загварын баталгаа олгох туршилт явуулах лабораторийг зааж өгч болно.



Дээр дурдсан НҮБ-ын дүрмээс гадна, энэхүү хэлэлцээрт ТХИБЗБОУС-ийг нэвтрүүлэх НҮБ-ын дүрмийг бий болгохоор тусгагдсан. Уг НҮБ-ын дүрэмд хэрэглэх цар хүрээ, захиргааны журам болон техникийн шаардлагыг заах бөгөөд уг НҮБ-ын дүрмийн нэг хувилбарт өөр өөр хатуу чанга түвшин бүхий техникийн шаардлагыг тусгаж болно.

Энэхүү хэлэлцээрийн 1 болон 12 дугаар зүйлийн бусад заалтыг үл харгалзан, ТХИБЗБОУС-ийн талаарх НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал дурдсан НҮБ-ын дүрмийн хамгийн сүүлчийн хувилбарын хатуу чанга шаардлагын хамгийн өндөр түвшний нөхцөлийн дагуу олгосон загварын баталгааг хүлээн зөвшөөрөх үүрэгтэй.

Энэхүү хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын бүх дүрэмд хамаарах Захиргааны болон үйл ажиллагааны заалтын талаарх хавсралтуудыг энэхүү хэлэлцээрт тусгасан бөгөөд Хэлэлцэн тохиролцогч бүх талд нэг, эсхүл түүнээс дээш НҮБ-ын дүрэм хамаарна.

3. НҮБ-ын дүрмийг баталсны дараа Ерөнхий нарийн бичгийн дарга энэ тухай Хэлэлцэн тохиролцогч бүх талд нэн даруй мэдэгдэх бөгөөд ингэхдээ Хэлэлцэн тохиролцогч аль тал уг НҮБ-ын дүрмийг үл зөвшөөрч байгааг, эсхүл зөвшөөрсөн гэдгээ мэдэгдсэн боловч хүчин төгөлдөр болох өдөртөө уг НҮБ-ын дүрмийг мөрдөж эхлэхгүй байх хүсэлтэй байгааг мэдэгдэнэ. Энэ тохиолдолд хэлэлцээр Хэлэлцэн тохиролцогч талд хүчин төгөлдөр болохгүй.

4. Баталсан НҮБ-ын дүрэм нь түүнийг үл зөвшөөрөх тухайгаа, эсхүл батлагдах өдөртөө уг дүрмийг мөрдөхгүй гэдгээ мэдэгдээгүй Хэлэлцэн тохиролцогч бүх талын хувьд энэхүү хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын дүрэмд заасан өдөр хүчин төгөлдөр болно.

5. Хэлэлцээрт нэгдэн орох тухай батламж жуух бичгийг хадгалуулах үедээ аливаа шинэ Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү хэлэлцээрт хавсаргасан зарим НҮБ-ын дүрэм, эсхүл тэдгээрийн алиныг ч дагаж мөрдөхгүй болохоо мэдэгдэж болно. Хэрэв энэ үед НҮБ-ын баталсан дүрэм, эсхүл уг дүрмийн төслийн талаар энэхүү зүйлийн 2, 3 болон 4 дэх заалтад заасан үйл ажиллагаа явуулж байгаа бол Ерөнхий нарийн бичгийн дарга шинэ Хэлэлцэн тохиролцогч талд тэрхүү төсөл, эсхүл баталсан дүрмийг хүргүүлэх бөгөөд энэхүү Хэлэлцэн тохиролцогч тал нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш зургаан сарын хугацаанд НҮБ-ын баталсан дүрмийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа мэдэгдээгүй бол шинэ Хэлэлцэн тохиролцогч талын хувьд уг НҮБ-ын дүрэм хүчин төгөлдөр болно. Ерөнхий нарийн бичгийн дарга Хэлэлцэн тохиролцогч бүх талд тухайн дүрэм хүчин төгөлдөр болох өдрийг мэдэгдэнэ. Түүнчлэн, Ерөнхий нарийн бичгийн дарга аливаа Хэлэлцэн тохиролцогч талын зүгээс энэхүү заалтын дагуу НҮБ-ын зарим дүрмийг дагаж мөрдөхгүй талаар гаргасан бүх мэдэгдлийг Хэлэлцэн тохиролцогч бүх талд хүргүүлнэ.

6. НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй аливаа Хэлэлцэн тохиролцогч тал тухайн НҮБ-ын дүрмийг хэрэглэхээ зогсоохоор эрмэлзэж буй тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад нэг жилийн өмнө хэдийд ч мэдэгдэж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг бусад Хэлэлцэн тохиролцогч талд хүргүүлнэ.



НҮБ-ын тухайн дүрмийн дагуу Хэлэлцэн тохиролцогч тухайн талын өмнө олгосон баталгаа нь энэхүү хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн заалтын дагуу цуцлагдаагүй бол хүчинтэй хэвээр байна.

Хэрэв Хэлэлцэн тохиролцогч тал НҮБ-ын дүрмийн дагуу баталгаа олгохоо зогсоосон бол дараах зүйлийг мөрдөнө:

- a) Өмнө нь загварын баталгаа олгосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тохиролд зохих хяналт тавина;
- b) НҮБ-ын дүрмийг үргэлжлүүлэн хэрэглэж байгаа аль нэг Хэлэлцэн тохиролцогч талаас бүтээгдэхүүн холбогдох шаардлагыг хангахгүй байгаа тухай мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд 4 дүгээр зүйлд заасны дагуу шаардлагатай арга хэмжээг авна;
- c) 5 дугаар зүйлд заасны дагуу баталгаа цуцалсан талаар Хэлэлцэн тохиролцогч бусад талд үргэлжлүүлэн мэдэгдэнэ;
- d) Олгогдсон баталгааг үргэлжлүүлэн сунгана.

7. НҮБ-ын дүрэм хэрэглэхгүй байгаа аливаа Хэлэлцэн тохиролцогч тал тухайн НҮБ-ын дүрмийг цаашид хэрэглэхээр эрмэлзэж байгаагаа Ерөнхий нарийн бичгийн даргад хэдийд ч мэдэгдэж болох бөгөөд энэ тохиолдолд уг НҮБ-ын дүрэм нь тийнхүү мэдэгдсэн өдрөөс хойш жар дахь өдөр тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хувьд хүчин төгөлдөр болно. Хэлэлцээрт шинээр нэгдэн орсон Хэлэлцэн тохиролцогч талын хувьд тухайн НҮБ-ын дүрэм энэхүү заалтын дагуу хүчин төгөлдөр болсон тухай бүр Ерөнхий нарийн бичгийн дарга Хэлэлцэн тохиролцогч бүх талд мэдэгдэнэ.

8. Аливаа НҮБ-ын дүрэм хүчин төгөлдөр үйлчилж буй Хэлэлцэн тохиролцогч талуудыг цаашид "НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талууд" гэнэ.

2 дугаар зүйл

1. Загварын баталгаагаар дамжуулан НҮБ-ын дүрмийг голчлон/түлхүү хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал бүр техникийн чадвартай бөгөөд батлагдсан загвартай тохирч байгааг баталгаажуулахад чиглэгдсэн зохицуулалттай нийцсэн тохиолдолд НҮБ-ын дүрмээр зохицуулагдаж буй дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангид уг НҮБ-ын дүрмийн дагуу загварын баталгаа, загварын баталгааны тэмдэг олгоно. Загварын баталгаа олгож буй Хэлэлцэн тохиролцогч тал бүр дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийг батлагдсан загварт нийцүүлэн үйлдвэрлэсэн болохыг баталгаажуулахын тулд зохих арга хэмжээг авсан гэдгийг батлах/хянах үүднээс энэхүү хэлэлцээрийн Хавсралт 1-т заасан шаардлагатай арга хэмжээг авна.

2. НҮБ-ын дүрмийн дагуу загварын баталгаа олгож буй Хэлэлцэн тохиролцогч тал бүр НҮБ-ын дүрмийг хариуцан Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагыг томилно. Уг Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь дурдсан НҮБ-ын дүрмийн дагуу загварын баталгааны талаарх бүх асуудлыг хариуцна. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь түүний нэрийн өмнөөс энэхүү зүйлийн

Гарын үсэг /Signature:

2022 оны 03 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

1 дэх хэсэгт заасан хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай туршилт, хяналт шалгалтыг явуулах/хийх техникийн үйлчилгээний байгууллагыг томилж болно. Хэлэлцэн тохиролцогч талуудын техникийн үйлчилгээний байгууллага нь энэхүү хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 2-т заасан шаардлагын дагуу үнэлэгдсэн, томилогдсон, мэдэгдсэн гэдгийг баталгаажуулна.

3. Дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийн төрлийн загварын баталгаа, загварын баталгааны тэмдэг болон ялгах тэмдэг/төрлийг тодорхойлогчийг НҮБ-ын дүрэмд тодорхой тусгах бөгөөд энэхүү хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 3-5-д заасан журмын дагуу олгоно.

4. Хэрэв дээр дурдсан нөхцөлийг хангаагүй бол НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал бүр НҮБ-ын дүрэмд тусгагдсан загварын баталгаа болон загварын баталгааны тэмдгийг олгохоос татгалзана.

3 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч талаас энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн дагуу дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангид загварын баталгаа олгосон бол дурдсан НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч бүх талын үндэсний хууль тогтоомжийн холбогдох хэсэгт нийцсэн гэж үзнэ.

2. Харилцан хүлээн зөвшөөрөх болон 1, 8, 12 дугаар зүйлийн заалт болон НҮБ-ын дүрэм дэх аливаа тусгай заалтыг мөрдөх замаар НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талууд эдгээр НҮБ-ын дүрмийн дагуу олгосон загварын баталгааг аливаа нэмэлт туршилт, баримт бичиг, баталгаа/гэрчилгээ, эсхүл тэмдэглэгээ шаардахгүйгээр өөрсдийн зах зээлд оруулахыг зөвшөөрнө.

4 дүгээр зүйл

1. Хэрэв НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал нь Хэлэлцэн тохиролцогч талуудын аль нэгнээс дурдсан НҮБ-ын дүрмийн дагуу олгосон загварын баталгааны тэмдэг бүхий зарим дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд анги нь батлагдсан загвар, эсхүл дурдсан НҮБ-ын дүрмийн шаардлагад нийцэхгүй байгааг илрүүлсэн тохиолдолд загварын баталгааг олгосон Хэлэлцэн тохиролцогч талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагад энэ тухай мэдэгдэнэ.

Загварын баталгаа олгосон Хэлэлцэн тохиролцогч тал нь үл тохирлыг залруулах талаар шаардлагатай арга хэмжээг авна.

2. 1.2 (b) дугаар зүйлд заасны дагуу НҮБ-ын дүрэмд тусгагдсан техникийн шаардлагыг дагаж мөрдөөгүйн улмаас үл нийцэл/үл тохирол үүссэн тохиолдолд загварын баталгаа олгосон Хэлэлцэн тохиролцогч тал нь нөхцөл байдлын талаар Хэлэлцэн тохиролцогч бусад бүх талд нэн даруй мэдэгдэх бөгөөд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Хэлэлцэн тохиролцогч талуудад холбогдох мэдээллийг тогтмол өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд олгосон баталгааг цуцалж болно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МЭН

Гарын үсэг / Signature

2022 оны 03 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, байгаль орчны хамгаалал, эрчим хүчний хэмнэлт, эсхүл хулгайгаас сэргийлэх технологийн шийдэлд үзүүлж буй бодит нөлөөллийг тооцоолсны дараа Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү үл тохирлыг/үл нийцлийг залруулах хүртэл өөрийн нутаг дэвсгэрт ийм дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийг ашиглах, худалдахыг хориглож болно. Энэ тохиолдолд эдгээр Хэлэлцэн тохиролцогч талууд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Захиргааны хорооны Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд 10.4 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг үл харгалзан, хэрэв энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан үл тохирох бүтээгдэхүүнийг 3 сарын дотор тохируулаагүй/нийцүүлээгүй бол загварын баталгааг хариуцсан Хэлэлцэн тохиролцогч тал баталгааг түр хугацаагаар, эсхүл бүрмөсөн цуцална. Онцгой тохиолдолд холбогдох НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй нэг, эсхүл хэд хэдэн Хэлэлцэн тохиролцогч тал эсэргүүцээгүй тохиолдолд уг хугацааг 3 сараас хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно. Хугацааг сунгах тохиолдолд, загварын баталгаа олгосон Хэлэлцэн тохиролцогч тал нь эхний 3 сарын хугацаанд холбогдох НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч бүх талд үл тохирлыг/үл нийцлийг залруулах зорилгоор хугацааг сунгах хүсэлтэй байгаагаа мэдэгдэж, сунгах үндэслэлийг гаргаж өгнө.

4. Хэрэв үл тохирол/үл нийцэл нь 1.2 (d) болон 1.2 (f) зүйлд заасан захиргааны заалт, загварын баталгааны тэмдэг, бүтээгдэхүүний тохирлын нөхцөл, эсхүл НҮБ-ын дүрэмд заасан мэдээллийн баримт бичгийг мөрдөөгүйгээс шалтгаалсан бөгөөд үл нийцлийг 6 сарын хугацаанд залруулаагүй бол загварын баталгаа олгосон Хэлэлцэн тохиролцогч тал баталгааг түр хугацаагаар, эсхүл бүрмөсөн цуцална.

5. Олгосон загварын баталгааг хариуцах Хэлэлцэн тохиролцогч тал нь загварын баталгааны тэмдэг бүхий тодорхой дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд анги нь НҮБ-ын дүрмийн шаардлага, эсхүл загварын баталгаанд нийцээгүй болохыг өөрөө олж тогтоосон тохиолдолд энэхүү зүйлийн 1-ээс 4 дэх заалт мөн адил үйлчилнэ.

5 дугаар зүйл

1. НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч бусад талын хүсэлтээр баталгааг цуцалсан, эсхүл баталгаа олгохоос татгалзсан дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийн жагсаалтыг хүргүүлнэ.

2. Үүнээс гадна НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч өөр нэг талаас хүсэлт хүлээн авсан бол энэхүү хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 5-ын заалтын дагуу тухайн НҮБ-ын дүрмийн дагуу дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийн баталгааг олгох, олгохоос татгалзах, эсхүл цуцлах шийдвэр гаргахад үндэслэсэн холбогдох бүх мэдээллийн хуулбарыг тухайн Хэлэлцэн тохиролцогч талд нэн даруй хүргүүлнэ.



3. Энэхүү хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 5-д заасны дагуу цаасан хуулбарыг цахим хувилбараар орлуулж болно.

6 дугаар зүйл

1. Европын Эдийн Засгийн Комиссын гишүүн улсууд, Комиссын үйл ажиллагааны журмын 8 дахь заалтын дагуу комиссын үйл ажиллагаанд зөвлөлдөх эрхтэйгээр оролцохоор зөвшөөрөгдсөн улс, түүнчлэн гишүүн улсууд нь энэхүү хэлэлцээрийн хамрах салбарын бүрэн эрх, түүний дотор гишүүн улс заавал дагаж мөрдөх шийдвэр гаргах бүрэн эрхээ шилжүүлсэн Европын Эдийн Засгийн Комиссын гишүүн улсуудын байгуулсан бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллага энэхүү хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал болж болно.

1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан саналын тоог тодорхойлоход бүс нутгийн эдийн засгийн интеграцын байгууллага нь Европын Эдийн Засгийн Комиссын гишүүн улсууд болох өөрийн гишүүн улсын тоотой тэнцэх тооны саналын эрхтэйгээр санал хураалтад оролцоно.

2. Европын Эдийн Засгийн Комиссын үйл ажиллагааны журмын 11 дэх заалтын дагуу Комиссын зарим үйл ажиллагаанд оролцох боломжтой НҮБ-ын гишүүн улсууд болон гишүүн улсууд нь энэхүү хэлэлцээрийн үйлчлэх салбарт хамаарах бүрэн эрх, түүний дотор гишүүн улсуудын хувьд заавал дагаж мөрдөх шийдвэр гаргах бүрэн эрхийг олгосон тэдгээр улсуудын бүс нутгийн эдийн засгийн интеграцын байгууллагууд энэхүү хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал болж болно.

1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан саналын тоог тодорхойлоход бүс нутгийн эдийн засгийн интеграцын байгууллагад нь НҮБ-ын гишүүн улсууд болох өөрийн гишүүн улсын тоотой тэнцэх тооны саналын эрхтэйгээр санал хураалтад оролцоно.

3. 1958 оны хэлэлцээрийн Оролцогч тал биш шинэ Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү хэлэлцээрт нэгдэн орох бол энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа батламж жуух бичгээ Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

7 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээр нь Ерөнхий нарийн бичгийн дарга түүнийг 1958 оны хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч бүх талд хүргүүлснээс хойш 9 сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү хэлэлцээрийг хүргүүлснээс хойш 6 сарын дотор 1958 оны хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал аливаа татгалзал илэрхийлсэн тохиолдолд энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болохгүй гэж үзнэ.

3. Энэхүү хэлэлцээрт шинээр нэгдэн орж буй аливаа Хэлэлцэн тохиролцогч талын хувьд хэлэлцээрт нэгдэн орох тухай батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш жар дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.



8 дугаар зүйл

1. Аливаа Хэлэлцэн тохиролцогч тал Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл хүргүүлэх замаар энэхүү хэлэлцээрийг цуцалж болно.

2. Цуцлалт нь Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 12 сарын дараа хүчин төгөлдөр болно.

3. Хэлэлцэн тохиролцогч талаас олгосон аливаа загварын баталгаа нь 8.2 дугаар зүйлийн дагуу хэлэлцээрийн цуцлалт хүчин төгөлдөр болсноос хойш 12 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.

9 дүгээр зүйл

1. Энэхүү хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасан аливаа Хэлэлцэн тохиролцогч тал хэлэлцээрт нэгдэн орох үедээ, эсхүл түүнээс хойш хэдийд ч Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл хүргүүлэх замаар энэхүү хэлэлцээр түүний гадаад харилцааг нь хариуцдаг нийт нутаг дэвсгэрт, эсхүл нутаг дэвсгэрийн аливаа хэсэгт мөрдөх/үйлчлэх тухай зарлаж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг хүлээж авснаас хойш жар дахь өдрөөс эхлэн энэхүү хэлэлцээр уг мэдэгдэлд заасан нутаг дэвсгэрт үйлчилнэ.

2. Энэхүү хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасан бөгөөд энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хэлэлцээрийг өөрийн гадаад харилцааг нь хариуцдаг/төлөөлөн харьяалдаг аливаа нутаг дэвсгэрт үйлчлэх/мөрдөх тухай зарласан аливаа Хэлэлцэн тохиролцогч тал хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасны дагуу тухайн нутаг дэвсгэрийн хувьд хэлэлцээрийг тусад нь цуцалж болно.

10 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэглэхтэй холбоотойгоор хоёр, эсхүл түүнээс дээш Хэлэлцэн тохиролцогч талын хооронд үүссэн аливаа маргааныг аль болох тэдгээрийн хоорондын хэлэлцээний замаар шийдвэрлэнэ.

2. Хэлэлцээний замаар шийдвэрлэж чадаагүй аливаа маргааныг маргаанд оролцогч аль нэг талын хүсэлтээр арбитра шилжүүлэх бөгөөд маргаанд оролцогч талуудын харилцан тохиролцож сонгосон нэг, эсхүл хэд хэдэн арбитраид шилжүүлнэ. Хэрэв маргааныг арбитраар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаснаас хойш 3 сарын дотор маргаанд оролцогч талууд нэг, эсхүл хэд хэдэн арбитрадыг тохиролцон сонгож чадаагүй тохиолдолд аль нэг тал нь тухайн маргааныг шийдвэрлэх нэг арбитрачийг томилуулах хүсэлтийг Ерөнхий нарийн бичгийн даргад гаргаж болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу томилогдсон арбитрач, эсхүл арбитрачдын гаргасан шийдвэрийг маргаанд оролцогч Хэлэлцэн тохиролцогч талууд заавал биелүүлнэ.

4. Энэхүү хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын дүрмийг хэрэглэх, эсхүл тайлбарлахтай холбоотой хоёр, эсхүл түүнээс дээш Хэлэлцэн тохиролцогч талын хооронд үүссэн аливаа маргааныг энэхүү хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 6-д заасан журмын дагуу хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.



11 дүгээр зүйл

1. Аливаа Хэлэлцэн тохиролцогч тал нь энэхүү хэлэлцээрт нэгдэн орох үедээ хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 1-3 дахь хэсгийг дагаж мөрдөхгүй тухай зарлаж болно. Бусад Хэлэлцэн тохиролцогч тал ийм тайлбар хийсэн аливаа Хэлэлцэн тохиролцогч талын өмнө 10 дугаар зүйлийн 1-3 дахь хэсгийг заавал дагаж биелүүлэх үүрэг хүлээхгүй.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу тайлбар хийсэн аливаа Хэлэлцэн тохиролцогч тал Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар тайлбараа хэдийд ч цуцалж болно.

3. Энэхүү хэлэлцээр, түүний Хавсралт, Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтууд болон хавсаргасан НҮБ-ын дүрэмд өөр ямар нэг тайлбар хийхийг зөвшөөрөхгүй, гэхдээ аливаа Хэлэлцэн тохиролцогч тал 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн дагуу зарим НҮБ-ын дүрмийг хэрэглэхгүй гэдгээ, эсхүл тэдгээрийн аль нэгийг хэрэглэхгүй гэдгээ мэдэгдэж болно.

12 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын дүрэмд дараах журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

1. НҮБ-ын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан Захиргааны хороо хавсралтад заасан журмын дагуу оруулна.

НҮБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсны дараа Захиргааны Хороо түүнийг НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

Үүний дараа НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч бүх талд болон Ерөнхий нарийн бичгийн даргад уг нэмэлт, өөрчлөлтийн талаар нэн даруй мэдэгдэнэ.

2. НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүргүүлснээс хойш 6 сарын дотор НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талуудын тавны нэгээс дээш хувь нь тухайн нэмэлт, өөрчлөлтийг үл зөвшөөрөх тухай мэдэгдээгүй тохиолдолд НҮБ-ын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанд тооцно. НҮБ-ын дүрмийн нэмэлт, өөрчлөлт батлагдмагц Ерөнхий нарийн бичгийн дарга нэн даруй НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талуудад нэмэлт, өөрчлөлт батлагдсан бөгөөд түүнийг заавал дагаж мөрдөх тухай мэдэгдэнэ.

3. НҮБ-ын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлах, хүчин төгөлдөр болохтой холбоотой шилжилтийн заалтыг багтааж болно. Хэлэлцэн тохиролцогч талууд НҮБ-ын дүрмийн өмнөх хувилбарын дагуу олгосон баталгааны дуусах огноог хүлээн зөвшөөрөх бөгөөд Хэлэлцэн тохиролцогч талууд нэмэлт, өөрчлөлт оруулсан НҮБ-ын дүрмийн өмнөх хувилбарын дагуу олгосон загварын баталгааг цаашид хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээхгүй байх огнооны эхлэл.



4. Хэдийгээр НҮБ-ын дүрмийн аливаа хувилбарын шилжилтийн заалтад өөрөөр заасан байж болох ч НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талууд нь НҮБ-ын дүрмийн өмнөх хувилбарт заасны дагуу загварын баталгаа олгож болох бөгөөд ингэхдээ энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн заалтыг дагаж мөрдөнө. Гэхдээ энэхүү зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талууд нь тэдгээр өмнөх хувилбарын дагуу олгосон загварын баталгааг хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээхгүй.

5. НҮБ-ын дүрмийг хэрэглэхээ зогсоох тухай хүсэлтээ Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэн Хэлэлцэн тохиролцогч талаас бусад НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй бүх Хэлэлцэн тохиролцогч тал тухайн НҮБ-ын дүрмийн хамгийн сүүлчийн хувилбарын дагуу олгосон баталгааг хүлээн зөвшөөрнө. НҮБ-ын дүрмийг хэрэглэхээ зогсоох тухай хүсэлтээ Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэн Хэлэлцэн тохиролцогч тал нь 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан нэг жилийн хугацаанд Ерөнхий нарийн бичгийн даргад өөрийн мэдэгдлийг хүргүүлэх үед тухайн Хэлэлцэн тохиролцогч талд хамаарах НҮБ-ын дүрмийн хувилбар-т заасны дагуу олгосон баталгааг хүлээн зөвшөөрнө.

6. Хэрэв шинэ технологи нь одоогийн мөрдөгдөж буй НҮБ-ын дүрэмд хамаарахгүй, эсхүл энэхүү НҮБ-ын дүрмийн нэг, эсхүл түүнээс дээш шаардлагад нийцэхгүй байвал НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч аливаа тал нь тухайн шинэ технологид суурилсан дугуйт тээврийн хэрэгслийн тодорхой нэг төрөл, тоног төхөөрөмж болон эд ангид НҮБ-ын дүрмийн дагуу шаардлагаас чөлөөлөгдөх баталгаа олгож болно. Энэ тохиолдолд энэхүү хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 7-д заасан журмыг мөрдөнө.

7. Хэрэв НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга НҮБ-ын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдэгдлээс хойш тухайн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд энэхүү хэлэлцээрт шинээр Хэлэлцэн тохиролцогч тал болон нэгдэн орох тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн даргад нэгдэн орох тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш 6 сарын дотор тухайн Хэлэлцэн тохиролцогч тал нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрөхгүй байгаа тухайгаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдээгүй бол уг НҮБ-ын дүрэм тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хувьд хүчин төгөлдөр болно.

13 дугаар зүйл

Хэлэлцээр болон түүний хавсралтын бичвэрт дараах журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Үүнд:

1. Аливаа Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү хэлэлцээр болон түүний хавсралтад нэг, эсхүл хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Хэлэлцээр болон түүний хавсралтад оруулахаар санал болгосон аливаа нэмэлт, өөрчлөлтийн бичвэрийг Ерөнхий нарийн бичгийн даргад илгээх бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга түүнийг Хэлэлцэн тохиролцогч бүх талд илгээхийн зэрэгцээ энэхүү хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бусад улсад мэдэгдэнэ.

2. Хэрэв санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхий нарийн бичгийн дарга



илгээсэн өдрөөс хойш 9 сарын хугацаанд аливаа Хэлэлцэн тохиролцогч тал татгалзал ирүүлээгүй тохиолдолд энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу илгээсэн, аливаа санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

3. Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар татгалзсан мэдэгдэл ирсэн эсэх талаар Хэлэлцэн тохиролцогч бүх талд аль болох эрт мэдэгдэнэ. Хэрэв санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар татгалзсан мэдэгдэл ирсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөгүйд тооцох бөгөөд нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болохгүй. Хэрэв татгалзсан мэдэгдэл ирээгүй тохиолдолд нэмэлт, өөрчлөлт нь энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан 9 сарын хугацаа дууссанаас хойш 3 сарын дараа бүх Хэлэлцэн тохиролцогч талын хувьд хүчин төгөлдөр болно.

13bis дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрт хавсаргасан Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад дараах журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

1.1. Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг энэхүү хэлэлцээрийн хавсралтын 7 дугаар зүйлд заасан журмын дагуу болон 1.1 дүгээр зүйлд тусгагдсан Захиргааны Хорооноос оруулна.

1.2. Захиргааны Хороо нь Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Үүний дараа Ерөнхий нарийн бичгийн дарга нэг, эсхүл түүнээс дээш НҮБ-ын дүрэм хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талуудад энэхүү нэмэлт, өөрчлөлтийн талаар нэн даруй мэдэгдэнэ.

2. Хэрэв Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүргүүлснээс хойш 6 сарын дотор нэг, эсхүл түүнээс дээш НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдээгүй бол Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсан гэж үзнэ.

3. Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар ямар нэгэн татгалзсан мэдэгдэл ирсэн эсэх талаар нэг, эсхүл түүнээс дээш НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талуудад аль болох эрт мэдэгдэнэ. Хэрэв санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар татгалзсан мэдэгдэл ирсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөгүйд тооцох бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь хүчин төгөлдөр болохгүй. Хэрэв татгалзсан мэдэгдэл ирээгүй тохиолдолд нэмэлт, өөрчлөлт нь энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан 6 сарын хугацаа дууссанаас хойш 3 сарын дараа нэг, эсхүл түүнээс дээш НҮБ-ын дүрэм хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч бүх талын хувьд хүчин төгөлдөр болно.

4. Шинэ хавсралтыг Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлт гэж үзэх бөгөөд ийм учир энэхүү зүйлд заасан ижил журмын дагуу боловсруулна.



14 дүгээр зүйл

1. Ерөнхий нарийн бичгийн дарга Хэлэлцэн тохиролцогч талуудад энэхүү хэлэлцээрийн заалтын дагуу дараах зүйлийг мэдэгдэнэ:

- (a) 6 дугаар зүйлийн дагуу хэлэлцээрт нэгдэн орох;
- (b) 7 дугаар зүйлийн дагуу энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох огноо;
- (c) 8 дугаар зүйлийн дагуу хэлэлцээрийг цуцлах;
- (d) 9 дүгээр зүйлийн дагуу мэдэгдэл хүлээн авах;
- (e) 11 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн дагуу хүлээн авсан тунхаглал болон мэдэгдэл;
- (f) 1 дүгээр зүйлийн 2, 3, 5, 7 дахь хэсэг болон 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу шинээр баталсан НҮБ-ын дүрэм болон одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй НҮБ-ын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох тухай;
- (g) 13^{bis} дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээр, эсхүл хавсралт, эсхүл Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох тухай;
- (h) Хэлэлцэн тохиролцогч тал 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн дагуу НҮБ-ын дүрмийг хэрэглэхийг зогсоох.

2. Энэхүү хэлэлцээр болон хэлэлцээрт хавсаргасан Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад заасны дагуу НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга дараах зүйлийг мэдэгдэнэ:


- (a) 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу НҮБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Ерөнхий нарийн бичиг дарга болон Хэлэлцэн тохиролцогч талуудад мэдэгдэх;
- (b) Хавсралт 7-ийн 5 дахь хэсгийн дагуу шаардлагаас чөлөөлөх баталгааны хүсэлтийн талаарх Захиргааны Хорооны шийдвэрийн тухай Хэлэлцэн тохиролцогч талуудад мэдэгдэх;

15 дугаар зүйл

1. Хэрэв дээрх заалтууд хүчин төгөлдөр болох үед хэлэлцээрийн өмнөх хувилбарын 1 дүгээр зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт заасан журмыг баримтлан НҮБ-ын шинэ дүрмийг баталж байгаа тохиолдолд тэрхүү НҮБ-ын шинэ дүрэм нь дээр дурдсан зүйлийн 4 дэх хэсгийн дагуу хүчин төгөлдөр болно.

2. Хэрэв дээрх заалтууд хүчин төгөлдөр болох үед хэлэлцээрийн өмнөх хувилбарын 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмыг баримтлан НҮБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа тохиолдолд тэрхүү нэмэлт, өөрчлөлт нь дурдсан зохицуулалтын дагуу хүчин төгөлдөр болно.

3. Хэрэв энэхүү хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч бүх тал зөвшөөрвөл



хэлэлцээрийн өмнөх хувилбарын нөхцөлийн дагуу батлагдсан НҮБ-ын аливаа дүрмийг дээрх заалтын нөхцөлийн дагуу батлагдсан НҮБ-ын дүрэм гэж үзнэ.

16 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийг Женев хотноо англи, франц, орос хэлээр тус бүр нэг хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр бүр адил хүчинтэй байна.



ЗАХИРГААНЫ ХОРООНЫ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

1 дүгээр зүйл

Захиргааны хорооны гишүүд нь нэмэлт, өөрчлөлт орсон хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч бүх талаас бүрдэнэ.

2 дугаар зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Европын Эдийн Засгийн Комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь Хорооны нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг гүйцэтгэнэ.

3 дугаар зүйл

Хороо нь жил бүрийн анхдугаар хуралдаанаараа Хорооны дарга болон орлогч даргыг томилно.

4 дүгээр зүйл

Шинээр НҮБ-ын дүрэм батлах, эсхүл НҮБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэ технологи (Хавсралт 7-д заасан)-ийг шаардлагаас чөлөөлөх баталгааны журмын дагуу мэдэгдэл хийх, эсхүл захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах бүрд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нь Хорооны хуралдааныг Европын Эдийн Засгийн Комиссын ивээл дор зарлан хуралдуулна.

5 дугаар зүйл

Санал болгосон НҮБ-ын шинэ дүрмийг батлахдаа төслийн талаар санал хураана. Энэхүү хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал улс бүр нэг саналын эрхтэй байна. Шийдвэр гаргахад хамгийн багадаа Хэлэлцэн тохиролцогч талуудын тэн хагасын ирц шаардлагатай байна.

Ирцийг тодорхойлоход, хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал болох бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нь өөрийн гишүүн улсуудын саналын эрхийн тоогоор санал өгнө. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгч нь тухайн бүрэлдэхүүн дэх тусгаар улсын саналыг уламжилж болно.

НҮБ-ын шинэ дүрмийн төслийг санал хураалтад оролцож буй гишүүдийн тавны дөрөвний саналаар батална.

6 дугаар зүйл

НҮБ-ын дүрэмд санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар санал хураана. НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал бүр нэг саналын эрхтэй байна. Шийдвэр гаргахад хамгийн багадаа НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй

Гарын үсэг /Signature: _____

2022 оны 03 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Хэлэлцэн тохиролцогч талуудын тэн хагасын ирц шаардлагатай байна. .

Ирцийг тодорхойлоход, хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал болох Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нь өөрийн гишүүн улсуудын саналын эрхийн тоогоор санал өгнө. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгч нь НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй түүний бүрэлдэхүүн дэх тусгаар улсын саналыг уламжилж болно.

НҮБ-ын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг санал хураалтад оролцож буй гишүүдийн тавны дөрөвний саналаар батална.

7 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрт хавсаргасан Захиргааны болон Үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар санал хураана. НҮБ-ын нэг, эсхүл хэд хэдэн дүрмийг хэрэглэж буй энэхүү хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал бүр нэг саналын эрхтэй байна. Шийдвэр гаргахад шаардлагатай буюу ирц хүчинтэй байх хамгийн бага тоо нь нэг, эсхүл хэд хэдэн НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй энэхүү хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч талуудын тэн хагасаас доошгүй байна.

Ирцийг тодорхойлоход, хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал болох Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нь өөрийн гишүүн улсуудын саналын эрхийн тоогоор санал өгнө. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгч нь нэг, эсхүл хэд хэдэн НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй түүний бүрэлдэхүүн дэх тусгаар улсуудын саналыг уламжилж болно.

Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийн талаарх хавсралтуудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг санал хураалтад оролцож буй гишүүд санал нэгтгэйгээр батална.

8 дугаар зүйл

Шинэ технологитой холбоотой санал болгосон шаардлагаас чөлөөлөгдөх баталгаа олгох Хэлэлцэн тохиролцогч талын хүсэлтэд санал хураана. НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал бүр нэг саналын эрхтэй байна. Шийдвэр гаргахад хамгийн багадаа НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талуудын тэн хагасын ирц шаардлагатай байна.

Ирцийг тодорхойлоход, хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал болох Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нь өөрийн гишүүн улсуудын саналын эрхийн тоогоор санал өгнө. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгч нь НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй түүний бүрэлдэхүүн дэх тусгаар улсын саналыг уламжилж болно.

Дурдсан Хэлэлцэн тохиролцогч талд шаардлагаас чөлөөлөх баталгаа олгох эрхийн асуудлыг санал хураалтад оролцож буй гишүүдийн тавны дөрөвний саналаар батална.



ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААЛТЫН ХАВСРАЛТ

Захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүд (SAPP)-ийн дараах хавсралтыг 1958 оны хэлэлцээрт² хавсаргасан бөгөөд 1958 оны хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын бүх дүрэмд хамаарах захиргааны болон үйл ажиллагааны нөхцөлүүдийг тодорхойлсон.

Хавсралт 1: Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тохирлын үнэлгээний журам

Хавсралт 2:

- 1 дүгээр хэсэг: Техникийн үйлчилгээний байгууллагын үнэлгээ, томилгоо болон мэдэгдэл
- 2 дугаар хэсэг: Энэхүү Хавсралтын 1 дэх хэсэгт заасан техникийн үйлчилгээний байгууллага дагаж мөрдөх стандарт
- 3 дугаар хэсэг: Техникийн үйлчилгээний байгууллагын үнэлгээний журам

Хавсралт 3: НҮБ-ын загварын баталгааны журам

Хавсралт 4: НҮБ-ын загварын баталгааг дугаарлах

Хавсралт 5: Баталгааны баримт бичгийг түгээх

Хавсралт 6: НҮБ-ын дүрмийн дагуу олгох загварын баталгаа болон НҮБ-ын дүрмийг хэрэглэхтэй холбоотой тайлбарын асуудлыг шийдвэрлэх журам

Хавсралт 7: Шинэ технологитой холбоотой шаардлагаас чөлөөлөх баталгааны журам

Хавсралт 8: Виртуал туршилтын аргын ерөнхий нөхцөл.

² Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын техникийн дүрмийг батлах, эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр



ХАВСРАЛТ 1:

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тохирлын журам

Зорилго

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тохирлын журам нь үйлдвэрлэсэн дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд анги бүр нь батлагдсан загварт тохирч байгааг баталгаажуулах зорилготой.

Журам нь дор "анхны үнэлгээ" гэж тусгасан чанарын удирдлагын тогтолцооны үнэлгээ болон дор "бүтээгдэхүүний тохирлын зохицуулалт" гэж тусгасан баталгаа олгох этгээдийн бүтээгдэхүүнтэй холбоотой хяналтыг салгахгүйгээр хамтад нь багтаана.

1. Анхны үнэлгээ

1.1. Хэлэлцэн тохиролцогч талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас НҮБ-ын загварын баталгаа олгохоос өмнө дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийг батлагдсан загварт нийцүүлэн үйлдвэрлэж байгаа эсэхийг үр дүнтэй хянаж шалгах үйлдвэрлэлийн журам, зохицуулалт байгаа эсэхийг нягтална.

1.2. Үнэлгээ хийх удирдамжийг "Аудитын удирдлагын тогтолцооны удирдамж" ISO 19011:2011 олон улсын стандартаас авч болно.

1.3. НҮБ-ын загварын баталгааг олгож буй эрх бүхий байгууллага нь 1.1 дэх зүйлд заасан шаардлагыг шалгана.

НҮБ-ын загварын баталгаа олгож буй Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь шаардлагатай үед энэхүү зүйлийн 1.3.1 болон 1.3.3 дахь заалтад заасан зохион байгуулалтын аль нэг, эсхүл нөхцөл байдлыг харгалзан эдгээр зохион байгуулалтыг бүрэн, эсхүл хэсэгчилсэн хосолсон зохицуулалтыг харгалзан үзэж анхны үнэлгээ болон дор 2 дугаар бүлэгт заасан бүтээгдэхүүний тохирлын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.

1.3.1. НҮБ-ын загварын баталгаа олгож буй Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага, эсхүл энэхүү эрх бүхий байгууллагыг төлөөлөн томилогдсон техникийн үйлчилгээний байгууллага нь анхны бодит үнэлгээг хийх болон/эсхүл бүтээгдэхүүний тохирлын үйл ажиллагааг хянана.

1.3.1.1. Анхны үнэлгээ хийх цар хүрээг Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага дараах зүйлтэй холбоотой боломжит мэдээллийг харгалзан үзнэ:

- a) Дор 1.3.3 дахь хэсэгт заасан боловч уг хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөгдөөгүй, эсхүл тэнцээгүй үйлдвэрлэгчийн гэрчилгээ;
- b) Тоног төхөөрөмж, эсхүл эд ангийн НҮБ-ын загварын баталгаа олгох үед тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгч тоног төхөөрөмж, эсхүл эд ангийн үйлдвэрлэгчийн ажлын байранд ISO9001:2008 олон улсын стандартын шаардлагад нийцэж буй аж үйлдвэрийн салбарын нэг, эсхүл хэд хэдэн техникийн шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн чанарын системийн үнэлгээ;



1.3.2. Хэлэлцэн тохиролцогч өөр нэг талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага, эсхүл энэхүү баталгаа олгох эрх бүхий байгууллагаас энэ зорилгоор томилсон техникийн үйлчилгээний байгууллага нь анхны бодит үнэлгээ болон/эсхүл бүтээгдэхүүний тохирлын үйл ажиллагааг хянах бөгөөд ингэхдээ уг Хэлэлцэн тохиролцогч тал нь НҮБ-ын загварын баталгаанд үндэслэсэн НҮБ-ын ижил төрлийн дүрмийг наад зах нь хэрэглэдэг байна.

1.3.2.1. Энэ тохиолдолд бусад Хэлэлцэн тохиролцогч талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь загварын баталгаа олгох бүтээгдэхүүн болон загварын баталгаа үндэслэсэн НҮБ-ын дүрэмтэй холбоотойгоор хамарсан салбар болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн талаар тайлбарласан зохицуулалтад нийцэж буй тухай мэдэгдэл бэлтгэнэ.

1.3.2.2. НҮБ-ын загварын баталгаа олгож буй Хэлэлцэн тохиролцогч талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн нийцлийн мэдэгдлийн талаарх хүсэлтийг хүлээн авмагц Хэлэлцэн тохиролцогч өөр нэг талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь нийцлийн мэдэгдлийг, эсхүл ийм мэдэгдлээр хангах боломжгүй байгаа талаар зөвлөмжийг нэн даруй илгээнэ.

1.3.2.3. Нийцлийн мэдэгдэлд дор хаяж дараах зүйлийг тусгасан байна:

- a) Групп, эсхүл компани (тухайлбал, XYZ автомашин);
- b) Тодорхой байгууллага (тухайлбал, Бүс нутгийн салбар, хэлтэс);
- c) Үйлдвэр/талбай (тухайлбал, Хөдөлгүүрийн үйлдвэр 1 (А улсад) Дугуйт тээврийн хэрэгслийн үйлдвэр 2 (В улсад));
- d) тээврийн хэрэгсэл/Бүрэлдэхүүн хэсэг/range(тухайлбал, М1 загварын бүх ангилал);
- e) Үнэлгээ хийгдсэн талбай (тухайлбал, хөдөлгүүрийн угсралт, их биеийг шахах, угсрах, тээврийн хэрэгслийг угсрах);
- f) Шалгасан баримт бичиг (тухайлбал, компани болон талбайн чанарын гарын авлага болон журам);
- g) үнэлгээний огноо (тухайлбал, аудит ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс ... оны ... дугаар сарын ...-ны өдөр хүртэл хийгдсэн);
- h) төлөвлөгөөт шалгалтын айлчлал (тухайлбал, сар/он);

1.3.3. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь ISO9001:2008 (энэхүү баталгааны хамрах хүрээ нь баталгаа олгох бүтээгдэхүүн (үүд)-ийг хамарсан байна) олон улсын стандарт, эсхүл түүнтэй адилтгах 1.1 дэх хэсгийн анхны үнэлгээний шаардлагыг хангасан магадлан итгэмжлэлийн стандартад нийцсэн үйлдвэрлэгчийн баталгааг хүлээн зөвшөөрч болно. Үйлдвэрлэгч нь баталгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллээр хангах бөгөөд энэхүү баталгааны хамрах/цар хүрээ, эсхүл түүний хүчин төгөлдөр байдлын талаарх аливаа өөрчлөлтийг эрх бүхий байгууллагад мэдээлж ажиллана.

1.4. Олон улсын Дугуйт тээврийн хэрэгслийн иж бүрэн загварын баталгааны хувьд тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж болон эд ангид НҮБ-ын баталгаа олгоход хийсэн анхны үнэлгээг давтан хийх шаардлагагүй боловч өмнөх үнэлгээнд



хамрагдаагүй хэсгийг ялангуяа иж бүрэн тээврийн хэрэгслийг угсрахтай холбоотой хэсгийг хамруулж, үнэлгээг бүрэн хийнэ.

2. Бүтээгдэхүүний тохирлын үйл ажиллагаа

2.1. 1958 оны хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын дүрмийн дагуу батлагдсан дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд анги бүрийг энэхүү хавсралт болон дурдсан НҮБ-ын дүрмийн шаардлагыг хангаснаар батлагдсан загварт тохируулан үйлдвэрлэсэн байна.

2.2. 1958 оны хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын дүрмийн дагуу загварын баталгаа олгож буй Хэлэлцэн тохиролцогч талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь батлагдсан загвартай тохирч буй эсэхийг тогтооход шаардлагатай туршилт, шалгалт, түүний дотор дурдсан НҮБ-ын дүрэмд заасан туршилт, шалгалтыг тодорхой хугацаанд явуулах талаар зохих үйл ажиллагаа болон хяналтын төлөвлөгөө гаргасан эсэхийг нягтлах бөгөөд баталгаа олгох бүрдээ эдгээр баримт бичгийг үйлдвэрлэгчтэй тохиролцоно.

2.3. НҮБ-ын загварын баталгаа эзэмшигч нь:

2.3.1. Бүтээгдэхүүн (дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд анги) батлагдсан загвартай тохирч байгаа эсэхийг үр дүнтэй хянах журам батлах, түүнийг хэрэглэдэг байхыг хангана/баталгаажуулна/хариуцна;

2.3.2. Батлагдсан загвар бүрийн тохирлыг туршихад шаардлагатай туршилтыг явуулах, эсхүл бусад тохирох тоног төхөөрөмжийг ашиглана;

2.3.3. Туршилт болон шалгалтын үр дүнгийн талаарх мэдээллийг бүртгэн хадгалах, хавсралт баримт бичгийг Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагатай тохиролцсоны дагуу тогтоосон хугацаанд хадгална. Энэхүү хугацаа нь 10 жилээс хэтрэхгүй байна.

2.3.4. Үйлдвэрлэлийн нөхцөлд гарч болох алдаа дутагдлыг харгалзан тооцож бүтээгдэхүүний үзүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, хянах зорилгоор туршилт, эсхүл шалгалт бүрийн үр дүнд дүн шинжилгээ хийнэ;

2.3.5. Бүтээгдэхүүний загвар бүрд дор хаяж энэхүү хавсралтад заасан шалгалт болон хэрэглэх НҮБ-ын дүрэмд тусгагдсан туршилтыг хийсэн байна;

2.3.6. Аливаа дээжийн багц, эсхүл туршилтын хэсэг холбогдох загварын шаардлагад нийцэхгүй байгааг илрүүлсэн тохиолдолд шинээр дээж авч, дахин туршилт явуулна. Тухайн бүтээгдэхүүний тохирлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.

3. Хяналт, шалгалтын үргэлжилсэн арга хэмжээ/үйл ажиллагаа

3.1. НҮБ-ын загварын баталгаа олгосон эрх бүхий байгууллага нь үйлдвэрийн нэгж бүрд хэрэглэж буй тохирлыг хянан шалгах аргыг хэдийд ч нягтлан шалгаж болно.



3.1.1. Энгийн арга хэмжээ нь энэхүү Хавсралтын 1 болон 2 дахь хэсэгт (анхны үнэлгээ ба бүтээгдэхүүний тохирлын үйл ажиллагаа) заасан журмыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхийг шалгана.

3.1.1.1. Техникийн үйлчилгээний байгууллага ((1.3.1 болон 1.3.2 хэсэгт шаардсаны дагуу шаардлага хангасан, эсхүл хүлээн зөвшөөрсөн)-аар хийгдэж буй тандалт шалгалтын үйл ажиллагаа нь анхан шатны үнэлгээний үед тогтоосон журамтай холбоотойгоор 3.1.1-д заасан шаардлагыг хангаж байвал хүлээн зөвшөөрөгдөнө.

3.1.1.2. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас хийх эдгээр шалгалтын ердийн давтамж (3.1.1.1 дэх хэсэгт зааснаас бусад) нь "Эрсдэлийн удирдлага – Зарчим ба Зааварчилгаа" ISO 31000:2009 олон улсын стандартын эрсдэлийн үнэлгээний аргачлалд заасан хугацааны давтамжтайгаар энэхүү хавсралтын 1 болон 2 дахь хэсэгт хамаарах холбогдох шалгалтыг явуулах нөхцөлийг хангасан байна. Ямар ч тохиолдолд хамгийн бага давтамж нь 3 жил тутамд нэг удаа байна. Энэхүү аргачлал нь Хэлэлцэн тохиролцогч талууд 1958 оны хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн дагуу хөндсөн үл тохирлын асуудлыг онцгой харгалзан үзнэ.

3.2. Хяналт шалгалт бүрд туршилт, шалгалтын бүртгэл болон бүтээгдэхүүний бүртгэл, ялангуяа 2.2 дахь хэсэгт шаардсаны дагуу хөтөлсөн хяналт, шалгалтын бүртгэлийг байцаагчид хянуулна.

3.3. Хянагч нь техникийн үйлчилгээний байранд, эсхүл үйлдвэрлэгчийн лабораторид туршилт хийх загварыг түүвэрлэн сонгож болно. Энэ тохиолдолд зөвхөн физик туршилтыг гүйцэтгэнэ. Дээжийн хамгийн бага тоог үйлдвэрлэгчийн өөрийн хяналт, шалгалтын үр дүнгийн дагуу тогтооно.

3.4. Хяналт шалгалтын түвшин шаардлага хангахгүй, эсхүл 3.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэсэн туршилтын хүчин төгөлдөр байдлыг шалгах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хянагч нь физикийн туршилтыг хийлгэхийн тулд техникийн үйлчилгээний байгууллага руу илгээх дээжийг сонгоно.

3.5. Хяналт шалгалт, эсхүл туршилтын хяналтын үед шаардлага хангахгүй үр дүн гарвал Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагын зүгээс бүтээгдэхүүний тохирлыг шинээр хангахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.



ХАВСРАЛТ 2:

Нэгдүгээр хэсэг. Техникийн үйлчилгээний байгууллагын үнэлгээ, томилгоо болон мэдэгдэл

1. Техникийн үйлчилгээний байгууллагын томилгоо

1.1. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь техникийн үйлчилгээний байгууллагыг томилоход техникийн үйлчилгээний байгууллага нь энэхүү Хавсралтын заалтыг мөрдөнө.

1.2. Техникийн үйлчилгээний байгууллага нь тусгайлан зөвшөөрөгдсөн журмаас бусад тохиолдолд НҮБ-ын дүрэмд тусгагдсан хяналт, шалгалт, эсхүл баталгаанд шаардлагатай туршилт, шалгалтыг хийх бөгөөд түүндээ хяналт тавьж ажиллана. Тэдгээр нь өөрийн чиг үүрэгт тусгагдаагүй туршилт, эсхүл хяналт шалгалтыг хийхийг хориглоно.

Техникийн үйлчилгээний байгууллагын гүйцэтгэл болон тэдний явуулж буй туршилт, шалгалтын чанар нь НҮБ-ын загварын баталгаа олгохыг хүссэн бүтээгдэхүүн нь техникийн үйлчилгээний байгууллагыг томилсон НҮБ-ын дүрэмд тусгагдсан шаардлагыг хангасан гэдгийг хангалттай шалгасан гэдгийг батална.

1.3. Техникийн үйлчилгээний байгууллагыг үйл ажиллагааны өрсөлдөөний салбараас хамаарч үйл ажиллагааны доорх дөрвөн ангиллын нэг, эсхүл хэд хэдэн ангиллын дагуу томилно. Үүнд:

- a) Ангилал А: өөрийн барилга байгууламжид/байранд НҮБ-ын дүрэмд заасан туршилтыг явуулах техникийн үйлчилгээний байгууллага;
- b) Ангилал В: Үйлдвэрлэгчийн барилга байгууламжид, эсхүл гуравдагч этгээдийн барилга байгууламжид НҮБ-ын дүрэмд заасан туршилтад хяналт тавих техникийн үйлчилгээний байгууллага;
- c) Ангилал С: Бүтээгдэхүүний тохирлыг хянах зорилгоор үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих, үнэлэх техникийн үйлчилгээний байгууллага;
- d) Ангилал D: Бүтээгдэхүүний тохирлын хяналт, шалгалтын үндсэн дээр туршилтыг хийх, шалгах, эсхүл хяналт тавих техникийн үйлчилгээний байгууллага.

1.4. Техникийн үйлчилгээний байгууллага нь түүнийг томилсон НҮБ-ын дүрэмд хамаарах тухайн салбартаа зохих мэргэжлийн ур чадвар, техникийн мэдлэг болон хангалттай туршлагатай гэдгээ нотолно.

Үүнээс гадна техникийн үйлчилгээний байгууллага нь түүнийг томилсон үйл ажиллагааны ангилалтай холбоотойгоор энэхүү Хавсралтын хоёрдугаар хэсэгт заасан стандартыг мөрдөнө. Гэхдээ уг стандартын дагуу магадлан итгэмжлэлийг заавал авсан байх шаардлагагүй.



Техникийн үйлчилгээний байгууллага нь туршилт, хяналт шалгалтын үнэн зөв байдал болон чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй сонирхогч талуудын аливаа хяналт болон нөлөөллөөс ангид гэдгийг баталгаажуулна.

Техникийн үйлчилгээний байгууллага нь түүнийг томилсон НҮБ-ын дүрэмд заасан туршилт, эсхүл хяналт шалгалтыг гүйцэтгэх, эсхүл хянан магадлахад шаардлагатай хэмжилт болон туршилтын тоног төхөөрөмж ашиглана.

1.5. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь 1.3 дахь хэсэгт тусгагдсан нэг, эсхүл хэд хэдэн үйл ажиллагааны хувьд техникийн үйлчилгээг гүйцэтгэж болно.

Техникийн үйлчилгээний байгууллагын үүргийг гүйцэтгэх Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагыг Хэлэлцэн тохиролцогч талын үндэсний хууль тогтоомжийн дагуу томилж, техникийн үйлчилгээний байгууллагаас санхүүжүүлэх үед энэхүү Хавсралтын заалт, эсхүл энэхүү Хавсралтын 1; 2 болон 3.4 дэх хэсгийн заалттай дүйцэх дүрэм, журмыг мөрдөнө. Үүнийг Хэлэлцэн тохиролцогч талын үндэсний хууль тогтоомжоор томилогдсон/байгуулагдсан техникийн үйлчилгээний байгууллага мөн мөрдөхийн зэрэгцээ, Хэлэлцэн тохиролцогч талын Засгийн газрын санхүүгийн болон удирдлагын хяналтад байна. Дүйцэх дүрэм, журам нь үйл ажиллагааны ижил түвшин болон бие даасан байдлыг баталгаажуулна.

1.6. 3.3 дэх заалтаас үл хамааран, үйлдвэрлэгч, эсхүл түүний төлөөлөгчийг зөвхөн уг томилгоо хийх заалтыг тусгасан НҮБ-ын дүрмийг хангах А ангиллын үйл ажиллагааг эрхлэх техникийн үйлчилгээний байгууллагаар томилж болно. Энэ тохиолдолд 1.4 дэх заалтаас үл хамааран уг техникийн үйлчилгээний байгууллага нь энэхүү Хавсралтын хоёрдугаар хэсгийн 1 дэх заалтад тусгагдсан стандартын дагуу магадлан итгэмжлэгдэнэ.

1.7. 1.5 болон 1.6 дахь заалтад тусгагдсан байгууллага нь 1 дэх заалтад тусгагдсан нөхцөлийг дагаж мөрдөнө.

2. Техникийн үйлчилгээний байгууллагын чадварыг үнэлэх

2.1. 1 дэх заалтад заасан чадварыг Эрх бүхий байгууллагаас³ гаргасан үнэлгээний тайланд тусгана. Үүнд магадлан итгэмжлэлийн байгууллагаас олгосон магадлан итгэмжлэлийн гэрчилгээг багтааж болно.

2.2. 2.1 дэх хэсэгт заасан үнэлгээг энэхүү Хавсралтын гуравдугаар хэсгийн заалтын дагуу хийнэ.

Үнэлгээний тайланг хамгийн ихдээ гурван жилийн дараа дахин хянана.

2.3. Үнэлгээний тайланг хүсэлтийн дагуу НҮБ-ын ЕЭЗК-ын Нарийн бичгийн дарга нарын газарт болон Хэлэлцэн тохиролцогч талуудад хүргүүлнэ.

2.4. Техникийн үйлчилгээний байгууллагын үүрэг гүйцэтгэж буй Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь баримт нотолгооны шаардлагыг мөрдөж байгаагаа батална.

³"Эрх бүхий байгууллага" гэж зөвшөөрөл эсхүл томилоо хийх эрх бүхий байгууллага, эсхүл тэдний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэлийн зохих байгууллага аль алиныг ойлгоно.



Үүнд үйл ажиллагаанаас хараат бус бие даасан аудитор үнэлгээ хийнэ дүгнэлт оруулна. Уг аудитор нь ижил байгууллагынх байж болох боловч үнэлгээ хийлгэж буй үйл ажиллагааг явуулж буй этгээдээс хараат бус байна.

2.5. Техникийн үйлчилгээг гүйцэтгэхээр томилогдсон үйлдвэрлэгч, эсхүл түүний төлөөлөгч нь 2 дахь хэсгийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

3. Мэдэгдэх журам

3.1. Хэлэлцэн тохиролцогч талууд томилогдсон техникийн үйлчилгээний байгууллага бүрийн нэр, хаяг (цахим хаягийг багтаан) болон үйл ажиллагааны ангиллын талаарх мэдээллийг НҮБ-ын ЕЭЗК-ын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Түүнчлэн цаашдын өөрчлөлтийн талаар НҮБ-ын ЕЭЗК-ын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

Мэдэгдэлд техникийн үйлчилгээний байгууллагыг НҮБ-ын аль дүрмийн дагуу томилсон болохыг тайлбарлана.

3.2. НҮБ-ын ЕЭЗК-ын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдсэн тохиолдолд зөвхөн техникийн үйлчилгээний байгууллага нь НҮБ-ын загварын баталгааны зорилгоор 1 дэх хэсэгт тодорхойлсон үйл ажиллагааг эрхэлж болно.

3.3. Тэдний эрхэлж буй үйл ажиллагааны ангиллаас үл хамааран хэд хэдэн Хэлэлцэн тохиролцогч талаас ижил төрлийн техникийн үйлчилгээг томилж, мэдэгдэл хүргүүлж болно.

3.4. НҮБ-ын ЕЭЗК-ын Нарийн бичгийн дарга нарын газар нь өөрийн цахим хуудсанд техникийн үйлчилгээний байгууллага болон Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагын жагсаалт, холбоо барих мэдээллийг нийтэлнэ.



Хоёрдугаар хэсэг. Энэхүү Хавсралтын нэгдүгээр хэсэгт заасан техникийн үйлчилгээний байгууллагын дагаж мөрдөх стандарт

1.НҮБ-ын дүрмийн дагуу гүйцэтгэх НҮБ-ын загварын баталгааны туршилтын үйл ажиллагаа

1.1. Ангилал А (өөрийн байранд гүйцэтгэсэн туршилт)

ISO/IEC 17025:2005 – Туршилтын лаборатори болон туршилтад тавигдах ерөнхий шаардлага

А ангиллын үйл ажиллагааг эрхлэхээр томилогдсон техникийн үйлчилгээний байгууллага нь түүнийг томилсон НҮБ-ын дүрмийн дагуу үйлдвэрлэгч, эсхүл түүний төлөөлөгчийн байранд, туршилт явуулах, эсхүл туршилтыг хянан шалгаж болно.

1.2. Ангилал В (үйлдвэрлэгчийн, эсхүл түүний төлөөлөгчийн байранд гүйцэтгэсэн туршилтыг хянан шалгах)

ISO/IEC 17020:2012 - Хяналт шалгалт гүйцэтгэж буй төрөл бүрийн байгууллагын үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага.

Үйлдвэрлэгчийн, эсхүл түүний төлөөлөгчийн байранд аливаа туршилтыг гүйцэтгэх, эсхүл хяналт шалгалт хийхийн өмнө техникийн үйлчилгээний байгууллага нь туршилт явагдаж буй байр болон хэмжих хэрэгсэл нь 1.1 дэх хэсгийн зохих шаардлагыг хангаж буй эсэхийг нягтална.

2. Бүтээгдэхүүний тохирлын үйл ажиллагаа

2.1. Ангилал С (үйлдвэрлэгчийн чанарын удирдлагын системийн анхан шатны үнэлгээ болон хяналт шинжилгээний аудитын журам)

ISO/IEC 17021:2015 – Удирдлагын системийн гэрчилгээжүүлэлт болон аудит хийх байгууллагад тавигдах шаардлага.

2.2. Ангилал D (бүтээгдэхүүний дээжийн хяналт, шалгалт эсхүл хяналт, шалгалтын магадлан шалгалт)

ISO/IEC 17020: 2012-Хяналт шалгалтыг хийх төрөл бүрийн байгууллагын үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага.



**Гуравдугаар хэсэг: Техникийн үйлчилгээний байгууллагын
үнэлгээний журам**

1. Зорилго

1.1. Хавсралт 2-ын энэхүү хэсэгт энэхүү хавсралтын нэгдүгээр хэсгийн 2 дахь хэсэгт заасан Эрх бүхий байгууллагын гүйцэтгэсэн техникийн үйлчилгээний байгууллагын үнэлгээний журмын нөхцөлийг тогтооно.

1.2. Эдгээр шаардлага нь тэдгээр байгууллагын (бие даасан байгууллага, үйлдвэрлэгч, эсхүл техникийн үйлчилгээний байгууллагын үүрэг гүйцэтгэх Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага) эрх зүйн байдлаас үл хамааран бүх техникийн үйлчилгээний байгууллагад хамаарна.

2. Үнэлгээний зарчим

Үнэлгээг хэд хэдэн зарчимд тулгуурлан хийнэ:

- а) Дүгнэлтийн шударга, бодит байдлын үндэс болох бие даасан байдал;
- б) Дүгнэлтийн найдвартай байдал болон дахин шинэчлэлтийг батлах нотолгоонд суурилсан арга зам.

Аудитор нь үнэнч шударга, итгэлцлийн зарчмыг харуулж, сонголт, нууцлалыг хүндэтгэнэ. Аудитор нь дүгнэлт болон цуглуулсан мэдээллийг үнэн зөвөөр тайлагнана.

3. Аудиторын ур чадвар

3.1. Үнэлгээг зөвхөн шаардлагатай техникийн болон удирдлага зохион байгуулалтын мэдлэгтэй аудитор хийнэ.

3.2. Аудитор нь үнэлгээний үйл ажиллагааны чиглэлээр тусгайлан бэлтгэгдсэн байна. Үүнээс гадна аудитор нь техник үйлчилгээний байгууллагын эрхэлж буй техникийн салбарын талаар тусгай мэдлэгтэй байна.

3.3. Дээр дурдсан 3.1 болон 3.2 дахь хэсгийг зөрчихгүйгээр, энэхүү хавсралтын нэгдүгээр хэсгийн 2.5 дахь хэсэгт заасан үнэлгээг үнэлгээ хийх үйл ажиллагаанаас хараат бус аудитор хийнэ.

4. Томилгооны хүсэлт

4.1. Хүсэлт гаргагч техникийн үйлчилгээний байгууллагын албан ёсны эрх бүхий төлөөлөгч нь холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор хүсэлт гаргана. Хүсэлтэд дараах зүйлийг заавал тусгасан байна:

- а) Хуулийн этгээд, нэр, хаяг, эрх зүйн байдал, хүний нөөц болон техникийн нөөц зэргийг багтаасан техникийн үйлчилгээний байгууллагын ерөнхий мэдээлэл;



- b) Хяналт шалгалт эсхүл туршилт хариуцсан ажилтны болон удирдах ажилтны намтар, боловсрол, мэргэжлийн ур чадварын нотолгоог багтаасан дэлгэрэнгүй тодорхойлолт;
- c) Дээрхээс гадна, виртуал туршилтын аргыг ашигладаг техникийн үйлчилгээний байгууллага нь компьютерын тусламжтай орчинд ажиллах чадвартай гэдгийг нотлох нотолгоог гаргаж өгнө.
- d) Техникийн үйлчилгээний байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл, тухайлбал түүний үйл ажиллагаа, томоохон аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагаатай эсэх (хэрэв байгаа бол), томилгооны хүрээнд хамаарах бүх байршлын хаяг гэх мэт;
- e) НҮБ-ын холбогдох дүрмээр шаардсан, томилогдсон техникийн үйлчилгээний байгууллагын томилгооны болон бусад үүрэг хариуцлагын шаардлагыг биелүүлэх тухай тохиролцоо;
- f) Техникийн үйлчилгээний байгууллага НҮБ-ын холбогдох дүрмийн хүрээнд эрхэлж буй тохирлын үнэлгээний үйлчилгээний тодорхойлолт болон техникийн үйлчилгээний байгууллагын хүчин чадлын хязгаарыг багтаасан түүний томилгооны хүсэлт гаргасан холбогдох НҮБ-ын дүрмийн жагсаалт;
- g) техникийн үйлчилгээний байгууллагын чанарын баталгааны гарын авлага, эсхүл үйл ажиллагааны харьцуулалтын дүрмийн хуулбар

4.2. Эрх бүхий байгууллага нь техникийн үйлчилгээний байгууллагаас ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг нягтална.

4.3. Техникийн үйлчилгээний байгууллага нь 4.1 дэх хэсгийн дагуу ирүүлсэн мэдээлэлдээ аливаа өөрчлөлт оруулахаар бол Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

5. Нөөцийг хянах

Эрх бүхий байгууллага нь өөрийн бодлого, ур чадвар болон шаардлагатай аудитор, шинжээчдийн хүртээмжийг харгалзан техникийн үйлчилгээний байгууллагын үнэлгээг хийж байгаа өөрийн боломжийг хянан шалгана.

6. Үнэлгээний туслан гүйцэтгэгч/гүйцэтгэх

6.1. Эрх бүхий байгууллага нь үнэлгээний тодорхой хэсгийг өөр томилогдсон байгууллагаар туслан гүйцэтгүүлэх, эсхүл мэргэжлийн бусад эрх бүхий байгууллагын техникийн шинжээчдээс дэмжлэг хүсэж болно. Хүсэлт гаргасан техникийн үйлчилгээний байгууллага нь туслан гүйцэтгэгч болон шинжээчийг хүлээн зөвшөөрнө.

6.2. Эрх бүхий байгууллага нь техникийн үйлчилгээний байгууллагын иж бүрэн үнэлгээг бүрэн хийхийн тулд зохих цар хүрээний магадлан итгэмжлэлийн гэрчилгээг харгалзан үзнэ.



7. Үнэлгээнд бэлтгэх

7.1. Эрх бүхий байгууллага нь албан ёсоор үнэлгээний багийг томилно. Эрх бүхий байгууллага нь үүрэг даалгавар бүрт зохих мэргэжилтэнг оруулахыг зохих байдлаар батална. Тухайлбал, үнэлгээний баг нь ерөнхийдөө:

- a) Томилогдон ажиллах салбарын үйл ажиллагааны талаар зохих мэдлэгтэй байна;
- b) Томилогдсон хүрээнд үйл ажиллагаа явуулж буй техникийн үйлчилгээний байгууллагын чадварыг найдвартай үнэлэх хангалттай мэдлэгтэй байх;

7.2. Эрх бүхий байгууллага нь үнэлгээний багт үүрэг даалгаврыг тодорхой өгнө. Үнэлгээний багийн үүрэг нь хүсэлт гаргагч техникийн үйлчилгээний байгууллагын ирүүлсэн баримт бичгийг хянах бөгөөд газар дээр нь үнэлгээг хийнэ.

7.3. Эрх бүхий байгууллага нь техникийн үйлчилгээний байгууллага болон томилогдсон үнэлгээний багтай хамтран үнэлгээний огноо, болон цагийн хуваарийг тохиролцоно. Гэхдээ, хяналт шалгалт, дахин үнэлгээний төлөвлөгөөний дагуу хугацааг мөрдөх нь Эрх бүхий байгууллагын үүрэг хэвээр байна.

7.4. Эрх бүхий байгууллага нь үнэлгээний багийг зохих шалгуурын баримт бичиг, өмнөх үнэлгээний бүртгэл, техникийн үйлчилгээний байгууллагын бүртгэл, холбогдох баримт бичгээр хангасан байна.

8. Газар дээр нь хийх үнэлгээ

Үнэлгээний баг нь нэг, эсхүл хэд хэдэн үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэх техникийн үйлчилгээний байгууллагын ажлын байранд техникийн үйлчилгээний байгууллагын үнэлгээг хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд техникийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа явуулдаг бусад сонгосон байршилд газар дээр нь мэдээлэл дүн шинжилгээ болон үнэлгээ хийнэ.

9. Цуглуулсан мэдээлэл болон үнэлгээний тайлангийн дүн шинжилгээ

9.1. Үнэлгээний баг нь баримт бичиг, хяналт шалгалтын бүртгэл болон газар дээрх үнэлгээнээс олж авсан холбогдох бүх мэдээлэл, нотлох баримтад дүн шинжилгээ хийнэ. Энэхүү дүн шинжилгээ нь үнэлгээний баг техникийн үйлчилгээний байгууллагын чадавхийг тодорхойлох болон томилгооны шаардлагыг хангаж буйг тодорхойлоход хангалттай байна.

9.2. Эрх бүхий байгууллагын тайлангийн журам нь дараах шаардлагыг хангасан байна.

9.2.1. Талбайг орхин явахын өмнө үнэлгээний баг болон техникийн үйлчилгээний байгууллага хооронд хурал зохион байгуулна. Уг хуралд үнэлгээний баг нь дүн шинжилгээнээс олж авсан мэдээллийн аман болон/эсхүл бичмэл тайланг гаргана.



Техникийн үйлчилгээний байгууллага нь илрүүлсэн зүйлсийн талаар үүнд үл нийцэл (хэрэв байгаа бол), тэдгээрийн үндэслэлийн талаар асуулт тавих боломжтой байна.

9.2.2. Үнэлгээний үр дүнгийн талаарх бичгээр гаргасан тайланг техникийн үйлчилгээний байгууллагад цаг тухайд нь танилцуулна. Энэхүү үнэлгээний тайланд тохирол болон чадамжийн талаарх тайлбарыг тусгах бөгөөд хэрэв ямар нэгэн үл тохирол/үл нийцэл гарсан тохиолдолд томилгоонд холбогдох бүх шаардлагыг хангахын тулд түүнийг шийдвэрлэх шаардлагатай.

9.2.3. Техникийн үйлчилгээний байгууллагыг үнэлгээний тайланд хариу өгөх, гарсан үл нийцлийг шийдвэрлэхийн тулд тогтоосон хугацаанд хийсэн авч хэрэгжүүлсэн, эсхүл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тусгай арга хэмжээг тодорхойлохыг хүснэ.

9.3. Холбогдох Эрх бүхий байгууллага нь техникийн үйлчилгээний байгууллагын хариу арга хэмжээ нь үл тохирлыг арилгахад хангалттай, үр дүнтэй байхыг баталгаажуулна. Хэрэв техникийн үйлчилгээний байгууллагын хариу хангалтгүй гэж үзвэл нэмэлт мэдээлэл шаардана. Үүнээс гадна хэрэгжүүлсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж байгааг нотлох баримт шаардах, эсхүл залруулах арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байгааг баталгаажуулахын тулд дараагийн үнэлгээг хийж болно.

9.4. Үнэлгээний тайланд хамгийн багадаа дараах зүйлийг багтаана:

- a) техникийн үйлчилгээний байгууллагын нэгдсэн тодорхойлолт;
- b) газар дээрх үнэлгээний огноо;
- c) үнэлгээнд оролцсон шинжээч/ болон/эсхүл аудиторын нэр;
- d) үнэлгээнд хамрагдсан бүх байрны нэгдсэн тодорхойлолт;
- e) үнэлгээ хийгдсэн томилгооны санал болгосон цар хүрээ;
- f) томилгооны шаардлагыг мөрдөх тухай зааварчилгааны дагуу байгууллагын чадавхыг дэмжиж буй техникийн үйлчилгээний байгууллагаас баталсан үйл ажиллагаа болон дотоод зохион байгуулалтын талаарх мэдээлэл;
- g) бүх үл тохирлыг шийдвэрлэсэн тухай мэдээлэл;
- h) хүсэлт гаргагчийг техникийн үйлчилгээний байгууллагаар томилох, эсхүл батлах эсэх тухай зөвлөмж, хэрэв батлах бол түүний томилгооны цар хүрээг тодорхойлох.

10. Томилгоог баталгаажуулах

10.1. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь холбогдох тайлан, мэдээллийг үндэслэн томилгоо хийх, түүнийг баталгаажуулах, хугацааг сунгах эсэх талаар хойшлуулшгүйгээр шийдвэр гаргана.

10.2. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас техникийн үйлчилгээний байгууллагад гэрчилгээ олгоно. Энэхүү гэрчилгээнд дараах зүйлсийг тусгасан байна:



- a) Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагын лого болон таних тэмдэг;
- b) томилогдсон техникийн үйлчилгээний байгууллагын нэгдсэн тодорхойлолт,
- c) томилгоо хүчин төгөлдөр болох, дуусах огноо,
- d) томилгооны цар хүрээний товч тайлбар, эсхүл лавлагаа (хэрэглэх НҮБ-ын дүрэм, эсхүл түүний хэсэг)
- e) энэхүү хавсралтын лавлагаа болон тохирлын мэдэгдэл.

11. Дахин үнэлэх болон тандалт

11.1. Дахин үнэлгээ хийх нь анхны үнэлгээтэй төстэй байх боловч өмнөх үнэлгээнээс олж авсан туршлагыг харгалзана. Газар дээрх үнэлгээний тандалт нь дахин үнэлгээнээс цар хүрээний хувьд бага байна.

11.2. Эрх бүхий байгууллага томилогдсон техникийн үйлчилгээний байгууллага бүрийн дахин үнэлгээний болон тандалтын төлөвлөгөөг боловсруулж, үүний үр дүнд томилгооны хамрах хүрээний төлөөлөл болох загварыг тогтсон хугацаанд үнэлнэ.

Газар дээр нь хийх үнэлгээ нь дахин үнэлгээ, эсхүл тандалт хийхээс үл хамааран хоорондын давтамж нь техникийн үйлчилгээний байгууллагын батлагдсан тогтвортой байдлаас хамаарна.

11.3. Тандалт, эсхүл дахин үнэлгээ хийх явцад үл тохирол илэрвэл Эрх бүхий байгууллага залруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд цагийн хатуу хязгаарлалтыг тавина.

11.4. Хэрэв залруулах, эсхүл хэрэгжүүлэх үйл ажиллагааг тохиролцсон хугацаанд гүйцэтгээгүй, эсхүл хангалттай гүйцэтгээгүй бол Эрх бүхий байгууллага дараагийн үнэлгээг явуулах, эсхүл томилогдсон техникийн үйлчилгээний байгууллагын нэг, эсхүл хэд хэдэн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, цуцлах зэрэг зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

11.5. Хэрэв Эрх бүхий байгууллагын зүгээс техникийн үйлчилгээний байгууллагын томилгоог түдгэлзүүлэх, эсхүл цуцлахаар шийдсэн бол энэ тухайгаа бүртгэлтэй цахим шуудангаар техникийн үйлчилгээний байгууллагад мэдэгдэх бөгөөд мөн НҮБ-ын ЕЭЗК-ын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Ямар ч тохиолдолд Эрх бүхий байгууллага нь техникийн үйлчилгээний байгууллагын хэрэгжүүлж байсан үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

12. Томилогдсон техникийн үйлчилгээний байгууллагын бүртгэл

12.1. Эрх бүхий байгууллага нь ур чадвар, томилгооны шаардлагуудыг үр дүнтэй биелүүлж байгааг бататгах техникийн үйлчилгээний байгууллагын бүртгэлийг хөтөлнө.



12.2. Эрх бүхий байгууллага нууцлалыг хангах үүднээс техникийн үйлчилгээний байгууллагын бүртгэлийг аюулгүй хөтөлж, хадгална.

12.3. Техникийн үйлчилгээний байгууллагын бүртгэлд заавал дараах зүйлсийг тусгана:

- (a) Холбогдох захидал харилцааны мэдээлэл;
- (b) үнэлгээний бүртгэл, тайлан;
- (c) томилгооны гэрчилгээний хуулбар.



ХАВСРАЛТ 3

НҮБ-ын загварын баталгааны журам

1. НҮБ-ын загварын баталгааны хүсэлт болон түүний хэрэгжилт

1.1. Үйлдвэрлэгч болон түүний төлөөлөгч (цаашид "хүсэлт гаргагч" гэх)-өөс НҮБ-ын загварын баталгааны хүсэлтийг Хэлэлцэн тохиролцогч талын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагад гаргана.

1.2. Тодорхой нэг төрлийн дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд ангид зөвхөн нэг хүсэлт гаргах бөгөөд уг хүсэлтийг НҮБ-ын загварын баталгаа хүссэн НҮБ-ын дүрмийг мөрдөж буй зөвхөн нэг Хэлэлцэн тохиролцогч талд гаргана. Батлагдах загвар бүрд тус тусад нь хүсэлт гаргана.

1.3. Энэхүү хүсэлтэд баталгаа хүссэн НҮБ-ын дүрэмд тусгагдсан мэдээллийг хавсаргана. Энэ мэдээлэлд шаардлагатай бүдүүвч, диаграмм, зураг зэргийг багтаасан батлагдсан тодорхой загварын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолтыг тусгана.

1.4. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагын зүгээс зөвшөөрөл шаардсан туршилтын, эсхүл эдгээр туршилтын гүйцэтгэлийг хөнгөвчлөх талаарх шийдвэртэй холбоотой шаардлагатай нэмэлт мэдээллээр хангахыг хүсэлт гаргагчаас шаардаж болно.

1.5. Хүсэлт гаргагч нь баталгаа хүсч буй НҮБ-ын дүрмээр шаардсан туршилтыг гүйцэтгэх зорилгоор Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагад шаардлагатай байгаа хамгийн олон тооны дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийг гаргаж өгнө.

1.6. НҮБ-ын дүрэмд тусгагдсан шаардлагыг дагаж мөрдөж буйг батлахын тулд батлагдах загвар бүхий дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангид зохих туршилтыг хийнэ.

Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагын зүгээс туршилтын зорилго нь хамгийн муу нөхцөлийн дор батлагдсан загварыг илэрхийлсэн тодорхой нэг төрлийн хувилбар, эсхүл хэлбэрийг сонгох замаар "хамгийн муу-хувилбар"-ын зарчмыг баримтална. Гаргасан шийдвэр болон түүний үндэслэлийг баталгааны баримт бичигт бүртгэнэ.

Гэхдээ, хүсэлт гаргагч Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр НҮБ-ын дүрмээр ("хамгийн муу-хувилбар") шаардагдах гүйцэтгэлийн түвшинг харгалзан хэд хэдэн тааламжгүй шинж чанарыг хослуулсан батлагдаагүй загвар бүхий дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийг сонгож болно.

"Хамгийн муу-хувилбар"-ыг сонгох шийдвэр гаргахад туслах зорилгоор виртуал туршилтын аргыг ашиглаж болно.



1.7. Техникийн үйлчилгээний байгууллага нь баталгаа олгох туршилтыг гүйцэтгэж, хяналт тавина. Туршилтад НҮБ-ын дүрэмд тодорхой заасан туршилтын журам, тусгай тоног төхөөрөмж болон багаж хэрэгслийг ашиглана.

1.8. Хэрэв НҮБ-ын холбогдох дүрэмд үүнийг тусгасан бөгөөд 1958 оны хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 8-д заасан ерөнхий нөхцөлийг хангасан бол дээрх 11.6 болон 1.7 дахь хэсэгт заасан туршилтын журмыг орлуулан хүсэлт гаргагчийн хүсэлтээр виртуал туршилтын аргыг ашиглаж болно.

1.9. Хэлэлцэн тохиролцогч талууд зөвхөн 1958 оны хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 1-ийн бүтээгдэхүүний тохирлын шаардлагыг хангасан тохиолдолд л загварын баталгааг олгоно.

1.10. Хэрэв баталгаа олгох туршилтаар тухайн загвар нь НҮБ-ын дүрмийн техникийн шаардлагыг хангаж байгаа нь нотлогдвол тухайн загварын баталгааг олгох бөгөөд 1958 оны хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 4-ийн дагуу баталгааны дугаарыг олгоно. Загварын баталгааны тэмдгийг холбогдох НҮБ-ын дүрмийн тусгай заалтын дагуу загвар бүрд олгоно.

1.11. Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь баталгаажуулалтын баримт бичигт дараах зүйлсийг тусгасан эсэхийг баталгаажуулна:

- a) хамгийн муу хувилбарын сонголтын бүртгэл болон уг сонголтын үндэслэл. Үүнд үйлдвэрлэгчээс ирүүлсэн мэдээлэл багтана;
- b) Аливаа чухал техникийн тайлбар хийсэн, туршилтын өөр арга хэрэглэсэн, шинэ технологийг нэвтрүүлсэн тухай бүртгэл;
- c) НҮБ-ын дүрмээр шаардсан туршилт болон хэмжилтийн бүртгэгдсэн үр дүн бүхий техникийн үйлчилгээний байгууллагын туршилтын тайлан;
- d) Батлагдах загварын үзүүлэлтийг зөв тогтоосныг харуулсан үйлдвэрлэгчийн мэдээллийн баримт бичиг;
- e) 1958 оны хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 1-ийн бүтээгдэхүүний тохирлын шаардлагыг хангасан тухай мэдэгдэл, тухайлбал 1958 оны хэлэлцээрт Хавсралт 1-ийн 1.3 дахь хэсэгт туссан үйл ажиллагаанд анхан шатны үнэлгээний үндэс суурь болгон авч үзэх, түүнчлэн анхан шатны үнэлгээний огноо болон аливаа тандалтын үйл ажиллагааны огноог нарийн тусгана.
- f) Загварын баталгааны гэрчилгээ.

2. НҮБ-ын загварын баталгааны нэмэлт, өөрчлөлт

2.1. Өөрийн үйлдвэрлэсэн дугуйт тээврийн хэрэгсэл, түүний тоног төхөөрөмж, эд ангид НҮБ-ын загварын баталгаа авсан үйлдвэрлэгч нь 1.3 дахь хэсэгт заасан мэдээлэлд бүртгэгдсэн загварын аливаа өөрчлөлтийг НҮБ-ын загварын баталгаа олгосон Хэлэлцэн тохиролцогч талд нэн даруй мэдэгдэнэ.

2.2. Хэлэлцэн тохиролцогч тал 2.5 болон 2.6 дахь хэсэгт тусгагдсан НҮБ-ын загварын баталгаанд нэмэлт, өөрчлөлт оруулах 2 журмын алийг нь мөрдөхөө



шийднэ. Шаардлагатай бол Хэлэлцэн тохиролцогч тал НҮБ-ын шинээр загварын баталгааг олгох талаар үйлдвэрлэгчтэй зөвлөлдөж шийднэ.

2.3. НҮБ-ын загварын баталгаанд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг зөвхөн НҮБ-ын загварын баталгааны эх хувийг олгосон Хэлэлцэн тохиролцогч талд гаргана.

2.4. Хэрэв Хэлэлцэн тохиролцогч тал НҮБ-ын загварын баталгаанд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор хяналт шалгалт, эсхүл туршилт хийх шаардлагатай гэж үзвэл энэ талаар үйлдвэрлэгчид мэдэгдэнэ.

2.5. Хэрэв мэдээллийн баримт бичиг болон туршилтын тайланд бүртгэгдсэн загварын нарийвчлал өөрчлөгдсөн бөгөөд Хэлэлцэн тохиролцогч талаас өөрчлөлт нь үйл ажиллагааны аюулгүй байдлын үзүүлэлт, эсхүл хүрээлэн буй орчинд мэдэгдэхүйц сөрөг нөлөөгүй, түүнчлэн ямар ч тохиолдолд тухайн загвар нь НҮБ-ын холбогдох дүрмийн шаардлагыг хангасан гэж үзвэл, НҮБ-ын загварын баталгааны өөрчлөлтийг "шинэчилсэн хувилбар" гэж тэмдэглэнэ.

Энэ тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч тал шаардлагын дагуу туршилтын тайлан болон мэдээллийн баримт бичгийн шинэчилсэн хуудсыг олгож, дахин олгосон огноо болон өөрчлөлтийг тодорхой харуулахын тулд шинэчилсэн хуудас бүрийг тэмдэглэнэ.

Туршилтын тайлан ба мэдээллийн баримт бичгийн нэгтгэсэн, өөрчлөгдсөн хувилбарын өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй тодорхойлолтын хамтаар энэхүү шаардлагыг хангасан гэж тооцно.

2.6. Хэрэв мэдээллийн баримт бичигт бүртгэгдсэн мэдээллийн өөрчлөлтөөс гадна дараах нөхцөл байдал байгаа бол НҮБ-ын загварын баталгаанд хийсэн нэмэлт, өөрчлөлтийг "сайжруулалт" гэж үзнэ:

- a) Цаашид хяналт шалгалт, эсхүл туршилт шаардлагатай; эсхүл
- b) Харилцаа холбооны баримт бичиг (түүний хавсралтаас бусад)-ийн аливаа мэдээллийг өөрчлөх; эсхүл
- c) Баталгаа хүчин төгөлдөр болсны дараа нэмэлт, өөрчлөлтийн дараагийн цувралд баталгаа хүсэх бөгөөд баталгааг нэмэлт, өөрчлөлтийн дараачийн цуврал шаардлага хангасан тохиолдолд олгоно.

2.7. НҮБ-ын загварын баталгаанд нэмэлт, өөрчлөлт оруулахыг батлах, эсхүл түдгэлзүүлэхэд өөрчлөлтийн агуулгыг тэмдэглэж, НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй 1958 оны хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч талуудад харилцаа холбооны маягтаар мэдэгдэнэ.

Үүнээс гадна харилцаа холбооны баримт бичигт хавсаргасан туршилтын тайлан болон мэдээллийн бичиг баримтын индексийг хамгийн сүүлчийн сайжруулалт хийсэн, эсхүл шинэчилсэн огноог харуулахаар өөрчилнө.

2.8. Загварын баталгаанд нэмэлт, өөрчлөлт хийж буй Загварын баталгаа олгох эрх бүхий байгууллага нь баталгааны дугаарыг 1958 оны хэлэлцээрт хавсаргасан Хавсралт 4-д заасны дагуу өмнө нь олгосон дараалсан нэмэлт, өөрчлөлтийн



дугаарын дагуу өссөн дугаараар шинэчлэн өөрчлөх бөгөөд энэхүү өөрчлөлтийн дугаараар тэмдэглэсэн харилцаа холбооны шинэчилсэн маягтыг олгоно.



ХАВСРАЛТ 4

НҮБ-ын загварын баталгааг дугаарлах

1. 1958 оны хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш Хэлэлцэн тохиролцогч талууд шинэ загварын баталгаа бүрд, мөн энэхүү баталгаанд нэмэлт, өөрчлөлт орох бүрд Хавсралт 3-ийн 1.10 болон 2.8 дахь хэсгийн дагуу загварын баталгааны дугаар олгоно.

2. 1958 оны хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсноос хойш НҮБ-ын дүрмийн аливаа хувилбар дахь баталгааны тэмдгийн заалтыг өөрөөр тайлбарласан байж болохыг үл харгалзан, шаардлагатай бол НҮБ-ын холбогдох дүрэмд тусгагдсан заалтын дагуу үйлдвэрлэгч баталгааны тэмдгийг хавсаргана, гэхдээ шинэ баталгаа олгосон, эсхүл уг баталгаа нь сунгагдсан дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд анги бүрд баталгааны дугаарын дагуу энэхүү Хавсралт заасанчлан баталгааны дугаарын 3 дахь бүлгийн тоонууд болон 2 дахь бүлгийн эхний хоёр тоог ашиглана.

Гэхдээ энэхүү нөхцөл нь НҮБ-ын дүрэм нь баталгааны код, эсхүл баталгааны дугаарын оронд баталгааны тэмдэгт ашиглагдах ялгах код шаардсан тохиолдолд хамаарахгүй. Гуравдугаар бүлэг хүртэл эхний тэгийг хасаж болно.

3. Баталгааны дугаарыг загварын баталгаа бүрд олгоно. Загварын баталгааны дугаар нь 4 бүлгээс бүрдэнэ. Бүлэг бүр "*" тэмдэгтээр хуваагдана.

Бүлэг 1. Том "E" үсгийн дараа загварын баталгаа олгосон Хэлэлцэн тохиролцогч талын ялгах дугаарыг бичнэ.

Бүлэг 2. НҮБ-ын холбогдох дүрмийн дугаар, дараагаар нь "R" үсэг, түүний дараа:

- Баталгаанд (НҮБ-ын дүрмийн анхны хувилбар бол 00 гэх) хамаарах НҮБ-ын дүрмийн техникийн нөхцөлийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийн серийн дугаарыг зааж буй хоёр тоо (эхний орон 0 байж болно);
- Баталгаанд (нэмэлт, өөрчлөлтийн анхны хувилбар бол серийн дугаарыг 00 гэх) хамаарах нэмэлт, өөрчлөлтийн серийн дугаарт орсон нэмэлт дугаарыг зааж буй нэг ташуу зураас болон хоёр тоо (эхний орон 0 байж болно);
- Хэрэв боломжтой бол хэрэгжүүлж буй үе шатыг зааж буй нэг ташуу зураас ба нэг, эсхүл хоёр тэмдэгт (-үүд).

Бүлэг 3. Дөрвөн оронтой дараалсан дугаар (эхний орон 0 байж болно). Дараалал 0001-ээс эхэлнэ.

Бүлэг 4. Нэмэлт өөрчлөлтийг илтгэх хоёр оронтой дараалсан дугаар (эхний орон 0 байж болно). Дараалал 00-оос эхэлнэ.

Бүх дугаарлалтыг араб тоогоор тэмдэглэнэ.

4. Ижил Хэлэлцэн тохиролцогч тал нь өөр загварын баталгаанд ижил дугаар олгохгүй.



Жишээ:

Анхны хувилбарт байгаа НҮБ-ын 58 дугаар дүрмийн дагуу Нидерланд Улсаас олгосон дөрөв дэх загварын баталгааны хоёр дахь нэмэлт, өөрчлөлтийн жишээ:

E4*58R00/00*0004*02

Жишээ:

Хөдөлгүүрийн түлшинд тавигдах шаардлагын дагуу хорт бодисын ялгаруулалттай холбоотой I зэрэглэлийн M, N1 ангиллын тээврийн хэрэгслийн хувилбар, нэмэлт өөрчлөлтийн гуравдугаар цуврал, НҮБ-ын 83 дугаар дүрмийн дагуу тээврийн хэрэгслийн баталгаанд зориулсан Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас олгосон 2439 дүгээр загварын баталгааны анхны нэмэлт, өөрчлөлтийн жишээ:

E11*83R03/00/J*2439*01



ХАВСРАЛТ 5.

Баталгааны баримт бичгийг түгээх

1. Хэрэв Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага баталгаа болон түүний хавсралтын хуулбарыг авах хүсэлт гаргасан, эсхүл шаардсан тохиолдолд тэдгээр баримт бичгийг цаасан хуулбараар, эсхүл цахим хэлбэрээр электрон шуудангаар, эсхүл НҮБ-ын ЕЭЗК-оос гаргасан интернетийн аюулгүй мэдээллийн санг ашиглан хүргүүлнэ.
2. Интернетийн аюулгүй мэдээллийн санд хадгалагдсан баримт бичиг нь дор хаяж НҮБ-ын дүрэм бүрд тусгагдсан баримт бичгээс бүрдэнэ. Үүнд Хэлэлцэн тохиролцогч талд мэдэгдсэн баталгааг сунгасан, түдгэлзүүлсэн, эсхүл цуцалсан тухай, эсхүл НҮБ-ын дүрмийн дагуу дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд ангийн төрлийн үйлдвэрлэлийг үндсэндээ зогсоосон тухай зэрэг баталгааны талаарх мэдэгдэл бүхий баримт бичиг орно.
3. Хэрэв дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд ангид хамаарах загварын баталгаа нь интернетийн аюулгүй мэдээллийн санд хадгалагдаж байгаа бол НҮБ-ын дүрмээр шаарддаг баталгааны тэмдгийг НҮБ-ын дүрэмд өөрөөр заагаагүй бол өмнө нь ялгах тэмдэг бүхий тусгай таних тэмдэг (UI -үл давтагдах дугаар)-ээр солино. Энэхүү тусгай таних тэмдэг нь мэдээллийн санд автоматаар үүсгэгдэнэ.
4. НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч бүх талууд тусгай таних тэмдэг ашиглан мэдээллийн санд хадгалагдсан НҮБ-ын тухайн дүрмийн талаарх мэдээллийг авах бөгөөд ингэснээр тусгай зөвшөөрөлтэй холбоотой холбогдох мэдээлэлд нэвтэрнэ.
5. Хэлэлцэн тохиролцогч талуудаас тогтоосон нэвтрэх эрхийн дагуу загварын баталгааны үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор 1958 оны хэлэлцээрт хавсаргасан НҮБ-ын дүрэм нь интернетийн аюулгүй мэдээллийн санг ашиглан загварын баталгааны электрон хуулбарыг дамжуулахыг шаардаж болно.



ХАВСРАЛТ 6.

НҮБ-ын дүрмийн дагуу олгох загварын баталгаа болон НҮБ-ын дүрмийг хэрэглэхтэй холбоотой тайлбарын асуудлыг шийдвэрлэх журам

1. НҮБ-ын загварын баталгааг олгохоос өмнөх тайлбарлах асуудлууд

НҮБ-ын загварын баталгааг хэрэглэхэд Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага НҮБ-ын дүрмийн хэрэглээний талаар тайлбар хийх шаардлагатай эсхүл баталгааны хүсэлт гаргагчийн зүгээс хүсэлт гаргасан бол шийдвэр гаргахаас өмнө Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага шаардлагатай мэдээллийг бусад эрх бүхий байгууллагад мэдээлж, тэднээс зөвлөмж авч ажиллана.

Баталгаажуулалтын эрх бүхий холбогдох байгууллага нь НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Баталгаажуулалтын эрх бүхий бусад байгууллагуудад хандаж үйлдвэрлэгчийн зүгээс дэмжлэг үзүүлж буй аливаа мэдээллийг багтаасан тайлбартай холбоотой санал болгож буй тэдний шийдэл болон холбогдох асуудлын талаар мэдэгдэнэ.

Ерөнхий дүрмийн дагуу үүнийг цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан хийнэ. Баталгаажуулалтын эрх бүхий бусад байгууллагын зүгээс холбогдох хариуг 14 хоногийн хугацаанд багтаан авна.

- a) Хүлээн авсан аливаа тайлбарыг судалж, хянан үзэж байгаа Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь шинэ тайлбарын дагуу баталгааг олгох боломжтой болно.
- b) Хэрэв хүлээн авсан тайлбарын дагуу шийдвэр гаргах боломжгүй бол Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь доорх 3 дахь заалтад тусгагдсан журмын дагуу нэмэлт тодруулгыг авна.

2. НҮБ-ын загварын баталгаа олгогдсоны дараах тайлбарлах асуудлууд

Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд янз бүрийн тайлбарууд байх тохиолдолд баталгааг олгосны дараагаар дараах журмуудыг дагаж мөрдөнө.

Эхний ээлжид холбогдох Хэлэлцэн тохиролцогч талууд харилцан зөвшилцөж асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

Үүний тулд харилцан хамтын ажиллагаа шаардлагатай бөгөөд Хэлэлцэн тохиролцогч тал бүрийн хувьд тайлбарын маргаан үүсээд байгаа дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж эсхүл эд ангийг хүлээн зөвшөөрөх ба туршилт хийх ашиглагдаж буй журмуудыг хянан шалгах шаардлагатай.

Дараах журмуудыг мөрдөн ажиллана:

- a) Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагын зүгээс ямар нэгэн алдааг олж илрүүлсэн, хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь 1958 оны хэлэлцээрийн нөхцөлүүд, ялангуяа хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийг дагуу арга хэмжээ авна.
- b) Одоогийн хэрэгжиж байгаа практикийн (Хэлэлцэн тохиролцогч аль нэгний) шинэ эсхүл ялгаатай тайлбар шаардсан нь зөвшилцөлд хүрсэн

Гарын үсэг /Signature:

2022 оны 03 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

тохиолдолд үүнийг НҮБ-ын холбогдох дүрмийг хэрэглэж буй бусад Хэлэлцэн тохиролцогч талуудад энэ тухай нэн даруй мэдэгдэнэ. Бусад Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү шийдвэрийн талаар 14 хоногийн дотор өгөх ба үүний дараагаар хүлээн авсан аливаа саналыг хянан үзэж байгаа Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь шинэ тайлбарын дагуу НҮБ-ын загварын баталгааг олгоно.

- c) Хэрэв зөвшилцөлд хүрч чадахгүй бол Хэлэлцэн тохиролцогч холбогдох талууд дор дурдсан 3 дахь заалтад тусгагдсан арбитрын үйл ажиллагаагаар маргааныг шийдвэрлүүлнэ.
- d) ямар ч тохиолдолд тухайн асуудлыг Тээврийн Хэрэгслийн дүрмийг уялдуулах тухай Дэлхийн Форум (WP.29)-ын эрх бүхий Ажлын хэсэгт танилцуулна. Хэрэв шаардлагатай гэж үзвэл эрх бүхий Ажлын хэсэг тайлбарын зөрүүг шийдвэрлэх зорилготой зохицуулалтын нэмэлт өөрчлөлтийн саналыг WP.29-д хүргүүлнэ.

3. WP.29 ба түүний эрх бүхий Ажлын хэсгүүдийн гүйцэтгэх арбитрын үйл ажиллагаа

Салбар Ажлын хэсгүүдийн дарга нар нь зөрүүтэй тайлбаруудыг шийдвэрлэхэд шаардлагатай цаг үеэ олсон боломжит арга замуудыг эрэлхийлэхийн зэрэгцээ НҮБ-ын дүрмийн дагуу НҮБ-ын загварын баталгаа олгох болон НҮБ-ын дүрмийг хэрэглэхтэй холбоотой Хэлэлцэн тохиролцогч талуудын дундах зөрүүтэй тайлбаруудаас үүдэн гарсан асуудлыг тодорхойлно.

Ажлын хэсгүүдийн дарга нар нь WP.29-д танилцуулахын тулд ийм төрлийн тайлбартай холбоотой асуудлыг шийдвэрлэх тохирсон арга хэмжээг авна. Үүнд:

- a) Холбогдох Хэлэлцэн тохиролцогч талуудын Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас гаргасан зөрүүтэй саналууд, түүнчлэн НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй бусад Хэлэлцэн тохиролцогч талуудын үзэл бодол, саналыг бүрэн авч хэлэлцэнэ.
- b) Шийдвэрүүд нь тухайн асуудлыг бүрэн авч үзэж, судалсны үндсэн дээр техникийн зохих зөвлөмж дээр үндэслэн гарна.
- c) Боломжтой бол санал нэгтэй шийдвэрийг гаргана; ба
- d) Үйл ажиллагаа/арга зам нь ил тод нээлттэй ба хянах боломжтой байна.

Хэрэв аливаа асуудлыг шийдвэрлэх шаардлага гарвал Ажлын хэсгийн дарга нь WP29-өөс урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр салбар Ажлын хэсгийн дараачийн хуралдаанд тухайн асуудлаар шинэ хэлэлцүүлгийг хийхээр хүргүүлнэ.

Энэ тохиолдолд Ажлын хэсгийн дарга нь уг үйл явцын тайланг WP.29-д аль болох эрт мэдээлнэ.

Арбитрын үйл ажиллагааны эцэст Ажлын хэсгийн дарга нь WP.29-д тайлангаа явуулна.

3.1. Асуудлыг одоогийн мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх боломжтой бол:



Ажлын хэсгийн хүлээн зөвшөөрсөн НҮБ-ын дүрмийн тайлбарыг хэрэгжүүлэх ба Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагууд НҮБ-ын зохих загварын баталгааг олгоно.

3.2. Асуудлыг одоогийн мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бол:

WP.29-д зохих ёсоор мэдэгдэх ба холбогдох салбар Ажлын хэсэгт дараачийн хуралдаанаараа энэхүү асуудлыг нэн түрүүнд хэлэлцэхийг шаардана.

Хуралдааны хөтөлбөрт зохих ёсоор нэмэлт оруулна.

Салбар Ажлын хэсэг нь тайлбартай холбоотой асуудлын талаарх аливаа саналыг хэлэлцэх ба зохих журмын дагуу НҮБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахаар WP29-д албан ёсны саналыг хүргүүлнэ.

WP29 нь дараачийн хуралдаанаараа тухайн асуудлыг нэн тэргүүнд хэлэлцэнэ.



ХАВСРАЛТ 7.

Шинэ технологитой холбоотой шаардлагаас чөлөөлөх баталгааны журам

1. НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талд үйлдвэрлэгчийн зүгээс энэхүү Хавсралтын 2-12 дахь заалтад тусгасан үйл ажиллагааны дагуу 1958 оны хэлэлцээрийн Захиргааны хорооноос олгох зөвшөөрлийн дагуу НҮБ-ын тухайн дүрмийн нэг ба хэд хэдэн шаардлагад үл нийцэх технологи ашигласан дугуйт тээврийн хэрэгсэл, түүний тоног төхөөрөмж эсхүл эд ангитай холбогдуулан НҮБ-ын дүрмийн дагуу зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх хүсэлтийг гаргаж болно.

2. Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг олгох эсэх, эсхүл ийм зөвшөөрлийг олгохгүй эсэхийг шийдэх хүртэл НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал зөвхөн өөрийн нутаг дэвсгэрт түр зөвшөөрөл олгож болно. НҮБ-ын тухайн дүрмийг хэрэглэж буй бусад Хэлэлцэн тохиролцогч талууд өөрсдийн нутаг дэвсгэрт түр зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөхөөр шийдвэрлэж болно.

3. Энэхүү Хавсралтын 2 дахь заалтад тусгагдсан түр зөвшөөрөл олгож буй Хэлэлцэн тохиролцогч тал нь өөрийн гаргасан шийдвэрийн талаар Захиргааны хороонд мэдэгдэх ба дараах зүйлс бүхий баримт материалыг хүргүүлнэ:

- a) НҮБ-ын дүрмийн шаардлага хангаагүй дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж эсхүл эд ангийг үйлдвэрлэх болсон зарчим эсхүл технологийн талаарх шалтгаанууд;
- b) Аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчны эсхүл бусад асуудлуудын тодорхойлолт ба авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд;
- c) Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх шаардлагуудаас дор хаяж аюулгүй байдлын ба хүрээлэн буй орчны хамгааллын тэнцвэрт байдал хангагдаж байгаа эсэх шаардлагуудыг харьцуулах, үүнийг илэрхийлж буй туршилтууд ба үр дүнгийн тодорхойлолт;
- d) Дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж эсхүл эд ангийн талаарх НҮБ-ын дүрэмд зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх зөвшөөрлийг олгох тухай зөвшөөрлийн хүсэлт.

4. Захиргааны хороо нь мэдэгдлийг хүлээн авсны дараагаар дараачийн хуралдаанаараа энэхүү Хавсралтын 3 дахь заалтад тусгагдсан мэдэгдлийг хэлэлцэнэ. Энэхүү мэдэгдлийг тухайн хуралдаанаас дор хаяж 3 сарын өмнө хүлээн авсан байна. Мэдэгдлийг хэлэлцсэний дараагаар Захиргааны хорооны зүгээс зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг олгох, эсхүл татгалзах, эсхүл эрх бүхий салбар Ажлын хэсэгт энэ асуудлыг шилжүүлэхээр шийдвэрлэнэ.

5. Захиргааны хорооны шийдвэр нь Хавсралтын 8 дугаар зүйлд тусгагдсан үйл ажиллагааны дагуу гарна.

6. НҮБ-ын ЕЭЗК-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар Захиргааны хорооны зөвшөөрлийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 1 сарын дотор мэдэгдэл гаргах цаг үеийн байдлаар НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талуудын тавны нэгээс илүү хувь нь НҮБ-ын ЕЭЗК-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт хандаж, зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай



зөвшөөрлийг олгохыг зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдэхээс бусад тохиолдолд энэхүү Хавсралтын 3 дахь заалтад тусгагдсан НҮБ-ийн дүрмийн дагуу зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх хүсэлтийг батлах эсэх асуудлыг хэлэлцэнэ.

7. Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл олгох эрхийг баталгаажуулахдаа НҮБ-ын ЕЭЗК-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газраас энэ тухайгаа НҮБ-ын холбогдох дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талуудад нэн даруй мэдэгдэнэ. Мэдэгдэл гаргасан өдрөөс хойш энэхүү Хавсралтын 3 дахь заалтад тусгагдсан Хэлэлцэн тохиролцогч тал НҮБ-ын дүрмийн дагуу зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг танилцуулна.

НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч тал зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа болон энэхүү зөвшөөрлийг шууд хүлээн зөвшөөрөөгүй эсхүл санал нэгдээгүй талуудыг НҮБ-ын ЕЭЗК-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг шууд хүлээн зөвшөөрөөгүй эсхүл санал нэгдээгүй Хэлэлцэн тохиролцогч талууд нь Захиргааны хорооны зөвшөөрлийн дагуу хожмын өдөр шаардлагаас чөлөөлөх баталгааны тухай зөвшөөрлийг хүлээн зөвшөөрч байгаагаа НҮБ-ын ЕЭЗК-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэх замаар хүлээн зөвшөөрч болно.

8. Захиргааны хороо нь зөвшөөрлийн шийдвэрт аливаа хязгаарлалт тавина. Хугацааны хязгаар нь 36 сараас багагүй байна. Хэлэлцэн тохиролцогч талуудын зүгээс НҮБ-ын дүрмийн өмнөх хувилбарт зөвшөөрөл олгоогүй бол зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөлд заасан технологийг хянан үзэх зорилгоор энэхүү Хавсралтын 9 ба 10 дахь заалтад заасны дагуу НҮБ-ын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах үед НҮБ-ын дүрмийг хэрэглэж буй Хэлэлцэн тохиролцогч талууд хугацааны хязгаар дуусгавар болох хүртэл зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг хүлээн зөвшөөрнө.

Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл олгохыг хүлээн зөвшөөрсөн Хэлэлцэн тохиролцогч талын зүгээс үйлдвэрлэгч энэхүү зөвшөөрөлтэй холбоотой бүх хязгаарлалтыг бүрэн дагаж мөрдөж байгаа бөгөөд харилцаа холбооны маягт нь Захиргааны хорооноос зөвшөөрөгдсөн зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх асуудалд үндэслэсэн болохыг тодорхой зааж байна гэдгийг баталгаажуулна.

9. Үүнтэй зэрэгцэн Захиргааны хорооноос зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн талаар НҮБ-ын дүрэм хариуцсан салбар Ажлын хэсэгт мэдэгдэнэ. Технологийн хөгжилтэй уялдуулахын тулд зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл олгохыг хүлээн зөвшөөрсөн Хэлэлцэн тохиролцогч тал нь зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл хүсэхтэй холбоотой НҮБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа НҮБ-ын дүрэм хариуцсан салбар Ажлын хэсэгт хүргүүлнэ. Саналыг энэхүү Хавсралтын 6 дахь заалтад заасны дагуу Захиргааны хорооны зөвшөөрлийн шийдвэрийг мэдэгдсэний дараагаар салбар Ажлын хэсгийн дараачийн хуралдаанаас хожимдуулалгүй хүргүүлнэ.

10. Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг олгосон технологийг харгалзан НҮБ-ын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон хүчин төгөлдөр болмогц



Үйлдвэрлэгч нь зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл олгосон НҮБ-ын өмнөх дүрмийг сольж, НҮБ-ын нэмэлт, өөрчлөлт орсон дүрмийн дагуу загварын баталгааг хэрэглэхийг хүлээн зөвшөөрнө.

Загварын баталгаа олгож буй Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага нь аль болох хурдан хугацаанд зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг цуцлах эсхүл ийм зөвшөөрлийг цуцлах талаар зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл олгодог Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

11. Хэрэв энэхүү Хавсралтын 8 дахь заалтад тусгагдсан цагийн хязгаар дуусгавар болохоос өмнө НҮБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаа бүрэн дуусаагүй бол энэхүү Хавсралтын 2 ба 3 дахь заалтад тусгагдсан үйл ажиллагааны дагуу хүлээн зөвшөөрсөн шийдвэрийг үндэслэн зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл олгосон Хэлэлцэн тохиролцогч талын хүсэлтээр уг зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацааг сунгаж болно.

Хэрэв энэхүү Хавсралтын 9 дэх заалтад тусгагдсан төвлөсөн хугацаанаас өмнө зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрөл олгохыг хүлээн зөвшөөрсөн Хэлэлцэн тохиролцогч тал НҮБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа хүргүүлээгүй бол тухайн Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү Хавсралтын 8 дахь заалтад тусгагдсан хугацааны хязгаарыг харгалзан үзэж энэхүү зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг нэн даруй цуцална. Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг цуцалсан Хэлэлцэн тохиролцогч тал энэ тухайгаа Захиргааны хороонд, тус Хорооны дараачийн хуралдааны үеэр мэдэгдэнэ.

12. Хэрэв Захиргааны хорооноос зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай зөвшөөрлийг олгохоос татгалзвал энэхүү Хавсралтын 2 дахь заалтад тусгагдсан түр зөвшөөрлийг олгосон Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү түр зөвшөөрлийг цуцална. Энэ тохиолдолд тухайн Хэлэлцэн тохиролцогч тал түр зөвшөөрлийг эзэмшигчид хандаж зөвшөөрөл олгосноос хойш 12 сарын хугацаанд түр зөвшөөрөл хүчинтэй байна гэдгийг харгалзан үзэж, шийдвэр гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор энэхүү Хавсралтын 2 дахь заалтад заасны дагуу олгосон энэхүү түр зөвшөөрөл хүчингүй болох болно гэдгийг мэдэгдэнэ.



ХАВСРАЛТ 8.

Виртуал туршилтын аргын ерөнхий нөхцөл

1. Виртуал туршилтын загвар

Дараах схемийг виртуал туршилтыг гүйцэтгэх болон тодорхойлох үндсэн бүтэц болгон ашиглана.

- a) Зорилго;
- b) Бүтцийн загвар;
- c) Хил хязгаарын нөхцөлүүд;
- d) Ачааллын таамаглал;
- e) Тооцоолол;
- f) Үнэлгээ;
- g) Баримтжуулах.

2. Компьютерын симуляц болон тооцооллын үндэслэл

2.1. Математик загварчлал

Математик загварчлалыг үйлдвэрлэгч гаргана. Үүнд НҮБ-ын холбогдох дүрэмд тусгагдсан шаардлагын дагуу туршигдсан дугуйт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж эсхүл эд ангийн бүтцийн нарийвчилсан асуудал болон түүний хил хязгаарын нөхцөлүүдийг тусгана.

Тээврийн хэрэгслийн бие даасан бүрэлдэхүүн хэсгүүдийг туршихад шаардлагатай өөрчлөлтийг оруулсан энэхүү нөхцөлүүд ижилхэн үйлчилнэ.

2.2. Математик загварчлалыг баталгаажуулах үйл явц

Бодит туршилтын нөхцөлүүдийг харьцуулах замаар математик загварчлалыг баталгаажуулна.

Энэхүү үр дүнг гаргахын тулд физикийн туршилтыг физикийн туршилтын үр дүн бүхий математик загварчлалыг ашиглаж, гарсан үр дүнг харьцуулах замаар хийнэ. Туршилтын үр дүнгийн харьцуулалтыг баталгаажуулна.

Баталгаажуулалтын тайланг үйлдвэрлэгч, эсхүл техникийн үйлчилгээний байгууллагаас боловсруулах ба Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

Математик загварчлал эсхүл баталгаажуулалтын тайланг хүчингүй болгох боломжтой програм хангамжид хийсэн аливаа өөрчлөлт баталгаажуулалтын үйл явцыг шинээр дахин хийхийг шаардаж болох Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагад танилцуулна.

2.3. Бичиг баримт

Загварчлал ба тооцоололд ашигласан мэдээлэл болон туслах хэрэгслүүдийг үйлдвэрлэгчээс гаргах ба техникийн үйлчилгээний байгууллагын зүгээс тохирох арга замаар баримтжуулна.



3. Багаж хэрэгсэл ба дэмжлэг туслалцаа

Баталгаажуулалтын эрх бүхий байгууллага эсхүл техникийн үйлчилгээний байгууллагаас шаардсаны дагуу үйлдвэрлэгч нь зохих програм хангамж зэрэг зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслийг нийлүүлэх, эсхүл нэвтрэх боломжийг олгоно.

Мөн үйлдвэрлэгч техникийн үйлчилгээний байгууллага эсхүл Баталгаажуулалтын эрх бүхий байгууллагад зохих дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

Техникийн үйлчилгээний байгууллагад нэвтрэх боломж олгох ба дэмжлэг, туслалцаа үзүүлсэнтэй холбогдуулан техникийн үйлчилгээний байгууллагын өөрийн ажилтны ур чадвар, зөвшөөрлийн эрхтэй холбоотой төлбөр, нууцлалтай холбоотой үүрэг хариуцлагаас техникийн үйлчилгээний байгууллагыг чөлөөлөхгүй.



ЖЕНЕВ ХОТНОО 1958 ОНД БАТЛАГДСАН "ДУГУЙТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД,
ТЭДГЭЭРТ СУУРИЛУУЛАН АШИГЛАЖ БОЛОХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭД АНГИД
ЗОРИУЛСАН НҮБ-ЫН УЯЛДУУЛАН ТОХИРУУЛСАН ТЕХНИКИЙН ДҮРМИЙГ
ХЭРЭГЛЭХ БОЛОН НҮБ-ЫН ЭДГЭЭР ДҮРЭМД ҮНДЭСЛЭН ОЛГОСОН БАТАЛГААГ
ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР"-ИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
УЛСЫН ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

1. С.Батболд – Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
2. Ё.Жаргалсайхан – Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
3. Ц.Нэргүйбаатар - Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч;
4. Ц.Баяржаргал - Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч;
5. А.Энхболд - Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн;
6. И.Базаррагчаа – ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн Тээврийн салбарын эрхлэгч.